


# ИРГЭДИЙН ТӨСӨВ



2023 ОНЫ БАТЛАГДСАН ТӨСВИЙН
МЭДЭЭЛЛИЙГ АШИГЛАВ

Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

**Swiss Agency for Development and Cooperation SDC**
**Швейцарын хөгжлийн агентлаг**

GLOBAL PARTNERSHIP FOR SOCIAL ACCOUNTABILITY

THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP

MASAM

Швейцарын хөгжлийн агентлаг болон Нийгмийн эгэх хариуцлагын дэлхийн түншлэлийн санхүүжилтээр Дэлхийн банкны хэрэгжүүлж буй “Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” буюу MASAM II төслийн хүрээнд тус аймгийн “Иргэдийн төсөв” эмхэтгэлийг бүтээв.

# АГУУЛГА:


04 МЭНДЧИЛГЭЭ
05 АЙМГИЙН МЭДЭЭЛЭЛ
06 ТӨСӨВ ГЭЖ ЮУ ВЭ?
07 АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ТАТВАРЫН ОРЛОГО
08 ОНХС
09 АЙМГИЙН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА
11 АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА
13 СУМДЫН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО, ЗАРЛАГА
15 АЙМГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
16 АЙМГИЙН ОНХС-ГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
80 СУМДЫН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ОНХС
81 НЭР, НЭРШЛИЙН ТАЙЛБАР
82 АЙМАГ, СУМЫН ЧИГ ҮҮРЭГ
83 ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

# МЭНДЧИЛГЭЭ



Сайн байцгаана уу? Эрхэм хүндэт уншигч Танд Дорнод аймгийн “Иргэдийн төсөв-2023” эмхэтгэл хүрч байгаад баяртай байна.

Таны төлсөн татвар төсвийг бүрдүүлэн, Улс, Эх орны ирээдүйг цогцлоож, хөгжүүлээд зогсохгүй эргээд Танд, Таны гэр бүл, үр хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, тав тухтай амьдралд хуваарилагддаг билээ.

Иргэд төсвийн талаарх мэдлэг, ойлголтоо сайжруулснаар төсөвт тавих хяналт, оролцоо нэмэгдэж, төсвийг үр дүнтэй зарцуулахад ихээхэн хувь нэмрээ оруулах боломжтой юм.

Дорнод аймгийн хувьд төсвөө өөрөө бүрдүүлдэг 6 аймгийн нэг юм. Бид аймгийн төсвөөр 84,5 мянган иргэнийхээ эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, дэд бүтцийг сайжруулах, хүн амын боловсролын чанар, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зэрэг ажлуудыг эрэмбэлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Мөн сумдыг төсвөө бие даан бүрдүүлдэг, сумынхаа хэмжээнд асуудлаа өөрийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэх чадамжтай сумдын тоог нэмэгдүүлэх бодлогыг баримталж байна.

Иймд Та бүхэнд Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлагдсан төсөв, түүний бүрдэл, зарцуулалтын мэдээллийг маш энгийн байдлаар эмхэтгэн толилуулж байна.

Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн

## ДОРНОД АЙМАГ

Ардын Засгийн газрын 1931 оны тогтоолоор Хан Хэнтий аймгаас туурга тусгаарлан Дорнод аймгийг анх байгуулсан. Дэлхийн 2-р дайны эхлэл болох 1939 оны Халхын голын дайнд Монгол, Зөвлөлтийн цэргүүд Японы эзлэн түрэмгийлэгчдийн эсрэг гарамгай тулалдаж, ялалт байгуулсан түүхтэй. Тус аймгийн Өвөг дээдсийн түүхийг өгүүлсэн X-XI зууны Киданы үеийн Хэрлэн барс хотын туурь, Хэрмэн зам, XI зууны үед хүний гараар бүтээгдсэн Их бурхант, Хүн чулуунууд, Угтамын хийдийн тууриудаас гадна 1939 оны Халхын голын түүхэн ялалтын хөшөөнүүд зэрэг түүхийн дурсгалт газрууд олонтой. Дорнод аймаг нь Монгол Улсын зүүн хэсэгт оршдог, 124000 км2 хавтгай дөрвөлжин км газар нутагтай, газар нутгийн хэмжээгээр улсдаа гуравдугаарт ордог ба 14 сум, 67 багтай, Халх, Буриад, Барга, Үзэмчин ястан оршин суудаг. Сүүлийн 3 жилд хүн амын тоо тасралтгүй өсөж 2021 оны байдлаар 84.575 буюу өнгөрсөн оноос 1.033 хүн амаар өссөн үзүүлэлттэй байна. Аймгийн төв Чойбалсан хотод 47.153 хүн оршин суудаг.

### НИЙТ ХҮН АМЫН ТОО

**123.597 мянган км2** газар нутагтай

**84.5 мянга**

50.5% | 49.5%

**14 сум**

**67 баг**

**24.7** мянган өрх

### ДНБ (тэрбум төгрөг)

| 2021 | 2022 |
|---|---|
| 78.4 | 99.5 |

| Хөдөө аж ахуй | Худалдаа, үйлчилгээ | Үйлдвэрлэл | Бусад |
|---|---|---|---|
| 31.6% | 50.0% | 9.2% | 9.2% |

*Урьдчилсан гүйцэтгэл




### Нийт малын тоо 3,342.3 мянган толгой



420.1 | 401.9 | 6.5 | 1,615.4 | 898.4

## ТӨСӨВ ГЭЖ ЮУ ВЭ?

Төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж зарцуулах хөрөнгө

## ТӨСВИЙН БҮТЭЦ:

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ**

- Улсын төсөв
- Нийгмийн даатгалын сангийн төсөв
- Ирээдүйн өв сангийн төсөв
- Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв
- Орон нутгийн төсөв

*УИХ 11-р сарын 15-ны дотор батална.*

**Аймаг, нийслэлийн төсөв**

*Аймаг, нийслэлийн ИТХ 12-р сарын 5-ны дотор батална.*

**Сум, дүүргийн төсөв**

*Сум, дүүргийн ИТХ 12-р сарын 20-ны дотор батална.*

## ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, ТЭНЦЭЛ:



## АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ТАТВАРЫН ОРЛОГО:

| 2022 оныг хүртэл: | 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөж буй |
|---|---|
| Нийслэл хотын албан татвар | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь (ШИНЭ) |
| Газрын төлбөрийн орлогын 60% | Нийслэл хотын албан татвар |
| Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар |
| Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр |
| Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр | Өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар |
| Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар | Улсын тэмдэгтийн хураамж |
| Өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар | Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 20 хувь |
| Улсын тэмдэгтийн хураамж | |
| Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 20 хувь | |

### ХЭРЛЭН БАРС ХОТЫН ТУУРЬ



Хэрлэн барс хот нь Монгол оронд байгаа Хятаны үеийн хотын туурь балгас юм. Энэхүү балгас нь Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутагт Чойбалсан хотоос баруун тийш 12 км-т Хэрлэн голын эрэгт оршино. Барс хотыг монгол нутаг дахь Хятаны үеийн X-XI зууны хот суурины томоохон дурсгалын нэг болохыг эрдэмтэд тогтоожээ. Нутгийнхны Барс хот гэж нэрлэдэг суварга бүхий их хэрэмт хотыг судлаачид Барс хот I гэж бичиж тэмдэглэх болжээ. Барс хот I-ийн их хэрмийн хэмжээ нь хааш хаашаа 1600-1800м, зузаан нь 4м, өндөр нь 1,52м юм. Хэрмийн дотор болон зүүн талд тав, долоон давхар 2 сувargатай байжээ. Хэрмийн баруун өмнөд хэсэгт өндөр шороон довжоон дээр чулуугаар барьсан бага хэрмийн ор бий. Тэр бага хэрмийн дотор дөрвөн барилгын суурьтай бөгөөд энэхүү бага хэрмийн орчимд 5-6 м-ийн хэмжээтэй дөрвөлжин барилгын ор арав гаруй байдаг. 1940-өөд он хүртэл хананд нь том бурхны зурагтай байжээ. Хөх тоосгоор барьсан таван давхар суварга нь өнцөг булангаасаа нурсаар өдий хүрчээ. Хэрлэн барс хотын малтлагаас олдсон олборуудын ихэнх нь бурхан шашны зүйл боловч, чухамдаа жинхэнэ хот цэргийн хуаран байжээ гэж эрдэмтэд үздэг.

## ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН:

Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилсан хөрөнгө.

### ИРГЭДИЙН ОРОЛЦОО:

Жил бүрийн 1-6 дугаар сарыг дуустал доорх 3 аргаар саналаа өгнө

1. Санал асуулгын хуудас
2. Бүлгийн хэлэлцүүлэг
3. ТӨЛӨВЛӨЛТ

Цахимаар санал өгөх боломжтой

Download on the App Store

GET IT ON Google Play

**ТӨСЛИЙН ЭРЭМБЭЛЭЛТ**

Төслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлэхэд оролцоно.

**ХЭРЭГЖИЛТ, ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гүйцэтгэнэ.

**ХЯНАЛТ**

Хяналт, шинжилгээ, үнэлгээний үйл явцад оролцоно

**ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА**

ОНХС-гийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг хадгалах, хамгаалахад оролцох мөн ашиглалтад хяналт тавих боломжтой.

### ОНХС-гийн эх үүсвэр:




- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
- Газрын тосны нөөц ашигласны төлбөр
- Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр
- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр
- Олон улсын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг

### МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ОРЛОГО:

ШИНЭ

Нэг малын тоо толгойд тухайн татварын жилд ногдуулах албан татварын хэмжээ нь 0-2000 төгрөг байна.

Албан татварын хэмжээг дээрхи хязгаарт багтаан сум, дүүргийн ИТХ малын төрөл тус бүрээр тогтооно.

**Дараах зүйлд зарцуулна. Үүнд:**

- Бэлчээрийн менежментийг сайжруулах;
- Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх;
- Малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;
- Малын чанарыг сайжруулах;
- Гэмт халдлага, гамшгаас хамгаалах;
- Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх;
- Малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх;
- Малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна.

# АЙМГИЙН 2023 ОНЫ ТӨСӨВ

**ОРЛОГО**

## АЙМГИЙН НЭГДСЭН ТӨСӨВ (сая төгрөг)

| | |
|---|---|
| Аймгийн төсвийн орлого | 34,025.7 |
| Сумын төсвийн орлого | 32,560.8 |
| Бусад орлого | 7,839.9 |
| Орон нутгийн төсвийн орлого | 74,426.4 |
| Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг | - |
| ОНХС-гийн орлогын шилжүүлэг | 17,943.1 |

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН



**НИЙТ ОРЛОГО 92,369.5**

## БАЙГАЛИЙН СОДОН БҮТЭЭЛ-ЗҮРХЭН АРАЛ



Дорнод аймгийн Баян-Уул сумын нутагт орших Онон мөрний “Таван салаа” хэмээх өвөрмөц нэгэн тогтоц бүхий газар оршдог. Ульхан уулын зүүн доохонд голын ус салаалан тохойрч их голдоо эргэн нийлэхдээ зүрхэн хэлбэрт арал үүсгэснийг “Онон мөрний Зүрхэн арал” хэмээн нэрлэж заншжээ. Эртний түүх домогт Ульхан уулыг ороон урссан энэхэн тохойг Онongийн таван салаа хэмээн нэрлэсэн ажээ. Үнэхээр л дунд өгүүлдэг аралтай тохойдоо умбасан алтанхан Онон энд угалз хээ мэт мушгиран, хөврөн урсана. Дэлхий дээр зүрхэн хэлбэртэй томоохон 21 арал байдгийн нэг нь Онон голын Зүрхэн арал юм байна.

# ЗАРЛАГА



**НИЙТ ЗАРЛАГА**
**92,369.5**

**Улсын төсөвт төвлөрүүлэх орлого**
3,623.9

## Орон нутгийн төсвийн урсгал зардал
**39,139.4**

- **9,998.5** Цалин хөлс, адилтгах зардал
- **10,340.4** Бараа үйлчилгээний зардал
- **18,423.7** Татаас, шилжүүлэг
- **376.8** Бусад зардал

## Хөрөнгийн зардал
**21,018.6**

- **3,225.8** Барилга, байгууламж
- **1,143.0** Их засвар
- **2,870.1** Тоног, төхөөрөмж
- **13,779.7** Бусад хөрөнгө

## ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН
**28,587.6**

- **12,311.6** Аймгийн ОНХС
- **16,276.0** Сумдын ОНХС

# ОРЛОГО

▲▼ өсөлт, бууралт /өмнөх оноос/

## АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО
**23,244.3** **-0.1▼**

### ТАТВАРЫН ОРЛОГО: 15,574.9 -18.1%▼

| Дүн | Өөрчлөлт | Орлого |
|---|---|---|
| 8,000.0 | -43.0%▼ | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар |
| 400.0 | 0.0%▼ | Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар |
| 3,424.9 | -13.3%▼ | Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр |
| 50.0 | -50.0%▼ | Улсын тэмдэгтийн хураамж |
| - | 0.0%▼ | Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр |
| 3,700.0 | 585.1%▲ | Татварын бусад орлого |

### ТАТВАРЫН БУС ОРЛОГО: 7,669.4 9.1%▲

| Дүн | Өөрчлөлт | Орлого |
|---|---|---|
| - | 0.0%▼ | Хувьцааны ногдол ашиг |
| 2,868.6 | 75.8%▲ | Өмч ашигласны болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого |
| 64.0 | -44.5%▼ | Төсөвт байгууллагын өөрийн орлого |
| 4,736.8 | -10.3%▼ | Бусад орлого |

| Дүн | Өөрчлөлт | Орлого |
|---|---|---|
| 6,754.2 | 8.8%▲ | ОНХС-гийн орлогын шилжүүлэг |
| 2,520.7 | -54.8%▼ | Урд оны үлдэгдэл |
| - | 0.0%▼ | Санхүүгийн дэмжлэг |
| 10,781.5 | -15.7%▼ | Сумаас төвлөрүүлэх орлого |

## НИЙТ ОРЛОГО
**43,300.7**
**-14.4%▼**

# ЗАРЛАГА

▲▼ өсөлт, бууралт /өмнөх оноос/

**НИЙТ ЗАРЛАГА 43,300.7 -14.4%▼**

| Дүн | Өөрчлөлт | Зардлын төрөл |
|---|---|---|
| 3,695.5 | -6.3%▼ | Нутгийн удирдлага |
| 293.0 | -94.1%▼ | Боловсрол, спорт |
| - | -100.0%▼ | Эрүүл мэнд |
| 1,121.8 | -40.8%▼ | Хот тохижилт, нийтийн аж ахуйн үйлчилгээ |
| 2,490.5 | 4.4%▲ | Хөтөлбөр, төсөл, арга хэмжээ |
| 12,311.6 | -23.8%▼ | ОНХС |
| 1,079.9 | -49.3%▼ | Бусад |
| 716.8 | -70.3%▼ | Байгаль орчин |
| 94.3 | -83.5%▼ | Соёл |
| 128.8 | -33.1%▼ | Нийгмийн хамгаалал |
| 1,298.2 | 15.2%▲ | Зам, тээвэр |
| 11,518.4 | 154.8%▲ | Хөрөнгө оруулалт |
| 1,736.6 | -3.3%▼ | Эргэн төлөгдөх зээл |

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

**АЙМГИЙН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА**
**36,485.4 -14.0%▼**

| Дүн | Өөрчлөлт | Төрөл |
|---|---|---|
| 3,191.4 | 33.9%▲ | Сумдад олгох санхүүгийн дэмжлэг |
| 3,623.9 | -37.5%▼ | Улсад төвлөрүүлэх орлого |

## СУМДЫН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО (сая төгрөг)

### ОРЛОГО

**ТАТВАРЫН НИЙТ ОРЛОГО:** **26,222.7** 21.2%▲

- **15,130.7** 8.0%▲ Хувь хүний орлогын албан татвар
- **5,020.7** 20.3%▲ Хөрөнгийн албан татвар
- **4,146.5** 90.6%▲ Газрын төлбөр
- **146.2** 19.2%▲ Байгалийн нөөц ашигласны төлбөр
- **1,778.6** 53.1%▲ Бусад татвар, төлбөр хураамж

**ТАТВАРЫН БУС ОРЛОГО:** **3,146.7** 18.3%▲

- Төсөвт байгууллагын өөрийн орлого **875.4** -28.3%▼
- Бусад орлого **2,271.3** 57.8%▲

Урд оны үлдэгдэл **5,319.1** 13.7%▲

Орлогын шилжүүлэг **11,188.9** 27.9%▲

Дээд шатны төсвөөс авах санхүүгийн дэмжлэг **3,191.4** 33.9%▲

▲▼ өсөлт, бууралт /өмнөх оноос/

**НИЙТ ОРЛОГО 49,068.8** 22.3%▲

### ШИНЭ СУМ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ



Халх гол шинэ сумын бүтээн байгуулалтыг ОХУ-ын "Роснефть" компанийн найман сая еврогийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн. ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины Монгол Улсад хийсэн айлчлалыг тохиолдуулан дараах барилга, байгууламжуудыг цогцоор нь Халх голын байлдааны түүхэн ойн хүрээнд 2019.09.03-ны өдөр хүлээлгэн өгсөн юм.

Шинэ сум бүтээн байгуулалтын ажлын хүрээнд Халхгол сумын Засаг даргын Тамгын газрын барилга, 250 хүний суудалтай соёлын төв, 20 ортой эмнэлэг, 650 хүүхдийн дунд сургууль, 150 хүүхдийн цэцэрлэг, 180 хүүхдийн дотуур байр, спорт заал зэрэг 11 байгууламж ашиглалтад орсон.

## СУМДЫН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА (сая төгрөг)

# ЗАРЛАГА

**НИЙТ ЗАРЛАГА**
**49,068.8**
22.3%▲

| | | |
|---|---|---|
| Нутгийн удирдлага | 9,928.9 | -6.0%▼ |
| Боловсрол, спорт | 2,666.5 | 0.0%▼ |
| Эрүүл мэнд | 390.0 | 0.0%▼ |
| Зам, тээвэр | - | 0.0%▼ |
| ОНХС | 16,276.0 | 30.4%▲ |
| Байгаль орчин | - | 0.0%▼ |
| Соёл | 305.6 | 0.0%▼ |
| Хот тохижилт, нийтийн аж ахуйн үйлчилгээ | 300.0 | 0.0%▼ |
| Хөрөнгө оруулалт | 5,373.5 | 168.6%▲ |
| Бусад | 3,046.8 | 33.9%▲ |

**10,781.5** -15.7%▲
Аймагт төвлөрүүлэх орлого

## НАЙРАМДАЛ ПАРК

1970-аад онд Монгол–Зөвлөлтийн ах дүүгийн найрамдалт харилцааны бэлгэдэл болон суурь нь тавигдаж байсан "Найрамдал парк"-ийг дорнодчууд орчин үеийн шинэ төлөвлөлттэйгээр сэргээн байгуулж Чойбалсан хотын хүүхэд залуучууд, ард иргэдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх төв болгон цэцэглүүлж байна. Нийтдээ 36.9 га талбайд соёл амралт, түүх, экологи, аялал жуулчлалын чиглэлээр явган зам, гүүр, талбай, хөшөө дурсгал, саравч сүүдрэвч, хүүхдийн тоглоомын талбай, спортын талбай, бүжгийн талбай, ахмадуудын талбай зэргийг тохижуулан засаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай зориулалтын зам талбай, нарны эрчим хүчний үүсгүүр бүхий байнгын эко гэрэлтүүлэг, 1293 м.кв талбай бүхий авто машины зогсоол зэргийг бүтээн байгуулсан байна.



**АЙМГИЙН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (сая төгрөг)**



Дорнод аймаг "ИРГЭДИЙН ТӨСӨВ - 2023"

**АЙМГИЙН ОНХС-ГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (сая төгрөг)**



## ХЭРЛЭН СУМ

Анх 1821 онд халхын Сэцэн ханы удмын Минжүүрдорж бэйсийн санаачилгаар шашин номын жасаа болон хошуу тамгын газар бүхий суурин энд барьж байгуулсан. 1923 онд Баянтүмэн хан уулын хошууны төв, 1931 оноос Дорнод аймгийн төв суурин болжээ. Улмаар Баянтүмэн 1938 онд хотын зэрэг олж, 1941 оноос нам, төрийн тэргүүний нэрээр "Чойбалсан" хэмээн тогтсон.

1994 оны 1-р сарын 26-ны өдөр хуралдсан Чойбалсан хотын ИТХ-ын ээлжит II чуулганаар, “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн дагуу Чойбалсан хотыг засаг захиргааны нэгжийн нь хувьд сум болгохоор “сум ба хотын нэрийн тухай” асуудлыг хэлэлцэж сумын нэрийг “Хэрлэн” гэж шинээр нэрлэж, хотын нэрийг “Чойбалсан” гэж батлах саналыг Засгийн газарт хүссэнээр шийдвэрлэжээ. Дараа нь Чойбалсан хот, Хэрлэн сумын ИТХ-ын 1994 оны 6-р сарын 24-ний ээлжит бус чуулганы тогтоол гарч УИХ-ын 1994 оны 33-р тогтоолоор Чойбалсан хотын засаг захиргааны нэгжийг Хэрлэн сум болгон зохион байгуулсан. Чойбалсан хот улсын нийслэл Улаанбаатараас 670 км зайд, Хэрлэн голын хөвөөн дээр оршино.

**281 км2 газар нутагтай.**




**СУМЫН ТӨСӨВ (сая төгрөг)**



## НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (сая.төг)

| Нийт | Улсын төсөв | Аймгийн төсөв | Сумын төсөв | Аймгийн ОНХС | Сумын ОНХС | Бусад |
|---|---|---|---|---|---|---|
| 96,773.6 | 68,106.3 | 9,400.9 | 2,533.3 | 10,878.1 | 2,429.7 | 3,425.3 |

## УЛСЫН ТӨСӨВ

- **342.4** Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн болон конторын барилга
- **797.9** Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн цэргийн гал тогооны барилга
- **193.8** Аймгийн төвийн 1800 айлын орон сууцны хорооллын цахилгаан хангамж, инженерийн шугам сүлжээ
- **91.2** Цэцэрлэгийн барилга
- **120.0** Цэцэрлэгийн барилга, 150 ор
- **1,541.2** Сургуулийн барилга, 640 суудал
- **976.7** Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 100 ор
- **241.5** Дотуур байрны барилга
- **1,631.3** Цэцэрлэгийн барилга, 150 ор
- **931.0** Спорт заалны барилга
- **25.9** Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, дугуйн зам, 5.5 км
- **19,461.3** Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 124.5 км
- **1,049.8** Үр тариа хадгалах агуулах
- **22,744.3** Дулааны цахилгаан станцын өргөтгөл
- **142.7** Эрүүл мэндийн төвийн барилга
- **6,372.8** Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хүүхдийн эмнэлгийн барилга, 200 ор
- **1,399.2** Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хүүхдийн нэгдсэн эмнэлгийн инженерийн шугам сүлжээ, дотоод засал, тоног төхөөрөмж
- **1,115.2** Музейн барилга /Дорнод, Хэрлэн сум/
- **168.5** Босоо тэнхлэг ба шинэ хотхоны авто зам /Дорнод, Хэрлэн сум/
- **8,759.6** Усан бассейн бүхий спорт цогцолборын барилга /Дорнод, Хэрлэн сум/

## АЙМГИЙН ТӨСӨВ

| | | | | |
|---|---|---|---|---|
| **25.1** Аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнгийн засвар, тохижилт | **450.0** “Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ-ын нэгдсэн авто гражийн материал | **53.5** Хэрлэн сумын 405, 406 дугаар байранд боловсон ариун цэврийн байгуулмж | **66.8** Дорнод аймагт 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын барилга, байгууламж, их засварын ажлын зураг төсвийн зардал | **80.0** Чойбалсан хөгжил ОНӨҮГ-ын авто машины сэлбэг хэрэгсэл худалдан авах |
| **100.0** Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын барилгын гадна засвар | **105.5** Хөгжимт драмын театрын үзэгчдийн танхимын шалны засвар | **110.1** Биеийн тамир спортын газрын барилгын засвар, тохижилт | **108.9** Орон нутгийн өмчийн барилга, байгууламжийн засвар | **41.5** Цагдаагийн газрын барилгын халаалт |
| **180.8** Эрчим хүчний дэд станц | **70.0** Хүүхдийн цэцэрлэгийн гадна зогсоол | **180.0** Спортын талбай | **420.0** Төрийн тусгай албан хаагчдын орон сууц | **75.0** Боловсролын болон спортын зарим байгууллагын албан хэрэгцээнд зөөврийн компьютер |
| **90.0** Тариалан эрхлэгчдийн хүнсний ногоо болон малчдын малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих зөөврийн сууц, тоног төхөөрөмж | **43.9** "Цахим худалдан авах ажиллагаа"-ны тоног төхөөрөмж, хэрэгсэл (Орон нутгийн өмчийн газар) | **30.7** Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд шаардлагатай тоног, төхөөрөмж | **20.0** Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагын тоног төхөөрөмж (Прокурорын газар) | **95.0** Нутгийн захиргааны шинэ барилгын камержуулалт, тоног, төхөөрөмж (Хэрлэн сум 7-р баг) |
| **35.0** Ерөнхий боловсролын сургуулийн тоног төхөөрөмж, тохижилт | **50.0** Өрхийн эрүүл мэндийн төвд эмнэлгийн тусламж үйлчилгээний автомашин ( Асралт-Үйлс ӨЭМТ, Ягаанцээнэ ӨЭМТ Хэрлэн сум) | **20.0** Мал эмнэлгийн лабораторын багаж, төхөөрөмж | **270.0** Дорнод аймагт 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын барилга, байгууламж, их засварын ТЭЗҮ, зураг төсөв | **240.0** Төсөл хөтөлбөр |

## АЙМГИЙН ТӨСӨВ

**300.0**
Хот байгуулалт Төсөл хөтөлбөр

**923.5**
Боловсролын салбарын Төсөл хөтөлбөр

**1,015.0**
Спорт, нийтийн биеийн тамир Төсөл хөтөлбөр

**343.6**
Төсөл хөтөлбөр

**894.0**
Соёл урлагын салбарын Төсөл хөтөлбөр

**5.0**
Төсөл хөтөлбөр

**1,450.3**
Төсөл хөтөлбөр

**63.2**
Хүнс, хөдөө аж ахуйн салбарын Төсөл хөтөлбөр

**31.5**
Төсөл хөтөлбөр

**315.0**
Эрүүл мэндийн салбарын Төсөл хөтөлбөр

**245.0**
Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэгийн барилгын шалны засвар

**568.7**
Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн барилгын дээврийн засвар

**138.9**
"Хан-Уул" цогцолбор сургуулийн спорт заалны барилгын шалны засвар

**145.3**
Ерөнхий боловсролын 11 дүгээр сургуулийн спорт заалны барилгын шалны засвар

## АЙМГИЙН ОНХС

**30.3**
Ивээл хорооллын дахин төлөвлөлтийн зураг төсөв боловсруулах

**25.3**
Чойбалсан хотын 2, 3 дугаар багийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын бүс байгуулах, хэсэгчлэн төлөвлөлтийн зураг төслийн зардал

**384.8**
Шинээр байгуулах хогийн цэгийг хашаажуулах ажлыг үе шаттайгаар хийх

**90.0**
Шинэ болон хуучин хогийн цэгийн тэлэлтийг багасгах арга хэмжээнд зарцуулах бараа материал

**220.0**
Илч хорооллын хайрган хучилттай авто замын хатуу хучилттай авто зам болгон барих (660 м)

**314.0**
Дорнод аймагт 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын барилга, байгууламж, их засварын ажлын зураг төсвийн зардал

**207.2**
Нийтийн орон сууцны байрны гадна шугам сүлжээг шинэчлэх

**69.0**
Нийтийн орон сууцны байрны гадна шугам сүлжээг шинэчлэх

**218.5**
Цахилгаан эрчим хүчний дэд станц

**30.0**
Цэцэрлэгийн барилгын засвар, тоног төхөөрөмж

## АЙМГИЙН ОНХС

**30.0**
Ерөнхий боловсролын сургууль, Соёлын төвийн тохижилт

**40.0**
Ерөнхий боловсролын сургуулийн барилгын цонх шинэчлэх

**200.0**
Ус, дулаан хангамж, бохир татан зайлуулах инженерийн шугам сүлжээний засвар

**505.7**
Усан хангамжийн эх үүсвэрийн Хэрлэн гол доогуурх дюкерийн байгууламж шинэчлэх ф400мм-ийн голчтой 180м шугам сүлжээ хаалт

**418.0**
Усан хангамжийн магистрал шугамыг шинэчилэх

**173.2**
Орон сууцны 10 дугаар байрны барилгын хучитгэл, бэхэлгээний ажил

**218.8**
9 дүгээр цэцэрлэгийн барилгын засвар

**83.4**
2 дугаар цэцэрлэгийн барилгын сантехникийн засвар

**80.0**
8 дугаар цэцэрлэгийн барилгын хаалга, гадна тамбурын ажил

**329.1**
Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн барилгын гадна засвар

**84.4**
Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн гадна дулааны шугамын засвар

**862.3**
Зангиат хороолол болон хүүхдийн цэцэрлэгийн дулаан, цэвэр, бохир ус, гадна цахилгаан, холбооны шугам)

**100.0**
Бохир татан зайлуулах шугам хоолой

**250.0**
Жимсний мод, хүнсний ногоо тариалахыг дэмжиж усан хангамжийг нэмэгдүүлэх, "Ногоон гудамж" төсөл хэрэгжүүлэх

**198.5**
"Шинэ усан сан-9" төсөл

**809.1**
Чойбалсан хотын төв авто замуудын орц, гарц (Хэрлэн сум)

**1,005.7**
Чойбалсан хот доторх хавтан хучилттай авто замыг шинэчилж шинээр тавих

**1,261.2**
Чойбалсан хотод авто зам шинээр тавих

**150.0**
Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн гадна авто зогсоол

**120.0**
Ялалт гүүрний 2 талд авто зам тавих ажлыг үргэлжлүүлэх

**300.0**
Хог хаягдал цэвэрлэх болон хуучин хогийн цэгийг дарж булшлах

**292.5**
Ягаан цэнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга

**110.0**
Эрүүл мэндийн төвд тоног,төхөөрөмж

**634.2**
Чойбалсан хотын усан хангамжийн шугам хоолойд усны чанар сайжруулах тоног төхөөрөмж суурилуулах

**16.4**
Чойбалсан хотын усан хангамжийн эх үүсвэрт, төмөргүйжүүлэх станцад камержуулалт

## АЙМГИЙН ОНХС

**40.0**
Багш хөгжлийн төвийн тоног төхөөрөмж

**100.0**
Эрүүл мэнд, боловсрол, хүүхэд хөгжлийн төвд лавлагаа, бүртгэлийн төхөөрөмж

**340.0**
Дорнод аймагт 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын барилга, байгууламж, их засварын ажлын зураг төсвийн зардал

**120.0**
Баяр наадмын зардал

**18.0**
"Мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг чадавхжуулах" төсөл

**35.0**
"Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд хөтөлбөр"-ийн хүрээнд "Элэгний В вирусын халдваргүй нярай", "Эхчүүдээ хайрлая" төслийг үргэлжлүүлэх

**60.0**
БЗДХ болон Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах төсөл

**70.0**
Зорилтот бүлгийн хүүхдүүдийг томуугийн вакцинд хамруулах арга хэмжээ

**57.1**
Сайн дурын дархлаажуулалтыг эрчимжүүлэх төсөл

**20.0**
"Эрүүл оюутан" төсөл

**14.4**
Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд алслагдсан багуудад эмийн сан ажиллуулах

**32.0**
Халдварт бус өвчинтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд "Вируст хепатит, элэгний хавдрыг эрт илрүүлэх" төсөл хэрэгжүүлэх

**50.0**
"Хөдөлгөөн-эрүүл мэнд" төсөл

**50.0**
"Зөв хооллолт-эрүүл мэнд" төсөл

**10.0**
Харшлаас сэргийлэх арга хэмжээг үргэлжлүүлэх

**75.0**
Ахуй үйлчилгээний төв байгуулах / 5 дугаар баг/

**55.0**
160 кВа 6/0.4 кВ дэд станц байгуулах / 11 дүгээр баг/

**20.0**
Хотын гудамжны хаягжуулалт

**137.0**
Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламж нэмэгдүүлэхэд шаардлагатай усалгааны асуудлыг шийдвэрлэх

**80.0**
Эгнээ гудамжнуудын дундуур явган хүн зорчих хэсгийн замыг сайжруулах хатуу хучилттай болгох /10 дугаар баг/

**65.0**
100 кВа 6/0.4 кВ дэд станц байгуулах / 3 дугаар баг/

**160.0**
Шинэ хашаа төсөл хэрэгжүүлэх / 2.3 дугаар баг/

**57.3**
Төв зам дагуух байгууллагуудын нэгдсэн хаягжуулалт

**50.0**
Хяналт постын барилга, тохижилт /5 дугаар баг/

**68.8**
Нийтийн эзэмшлийн талбайд тохижилт хийх / 10 дугаар баг/

## СУМЫН ТӨСӨВ

**20.0**
Цагдан хорих байрны засвар /Материалын үнэ/

**85.4**
Сургуулийн барилгыг хэсэгчилсэн засвар /11 дүгээр сургууль/

**100.0**
Чойбалсан хотын цэвэр усны шугам сүлжээг хэсэгчлэн засварлах, шинэчлэх

**51.6**
Чойбалсан хотын гудамж, зам талбайн телехяналтын нэгдсэн системийн төв болон стандартад нийцсэн серверийн өрөө байгуулах /Цагдаагийн газар/

**10.0**
Эрүүгийн цагдаагийн тасгийн өрөөний дотор засвар /Цагдаагийн газар/

**24.6**
Хотын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх /Нийтийн эзэмшлийн гудамжны гэрэлтүүлэг,тохижилт/

**73.6**
Орон сууцны орцны хаалга шинэчлэн засварлах / 4,10 дугаар баг/

**140.0**
Сургуулийн барилгыг хэсэгчилсэн засвар /1 дүгээр сургууль/

**4.4**
Төсөвт байгууллагын барилгын гадна гэрэлтүүлэг /6 дугаар цэцэрлэг/

**19.9**
Халаалтын тогооны засвар / 3 дугаар баг/

**20.0**
Гадна дулааны шугамын хэсэгчилсэн засвар / 10 дугаар цэцэрлэг/

**20.0**
Улсын нөөцийн тэжээлийн агуулахын дээврийн хэсэгчлэн засвар /Материалын үнэ/

**15.9**
Хотын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх /Орон сууц 6 дугаар баг/

**19.8**
Хотын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх /Нийтийн эзэмшлийн гудамжны гэрэлтүүлгийн засвар үйлчилгээ/

**16.9**
Сургуулийн барилгын гадна гэрэлтүүлэг / 12 дугаар сургууль/

**10.4**
Тоног төхөөрөмж сайжруулах /8-р сургууль/

**20.0**
Компьютер, тоног төхөөрөмж сайжруулах /боловсролын байгууллагууд/

**16.0**
Камержуулалт /1 дүгээр цэцэрлэг/

**15.0**
Анги танхимын сурагчийн ширээ сандлыг үе шаттайгаар шинэчлэх /Хан-уул цогцолбор сургууль/

**15.0**
Анги танхимын сурагчийн ширээ сандлыг үе шаттайгаар шинэчлэх /1-р сургууль/

**5.5**
Киоск төхөөрөмж худалдан авах

**40.0**
Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шаардлагатай автомашин /Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар/

**20.0**
Иргэний танхимын тоног төхөөрөмжийг сайжруулах /сумын ЗДТГ/

**9.1**
Тоног төхөөрөмж сайжруулах /3 дугаар цэцэрлэг/

**200.0**
Хотын нийт эзэмшлийн гудамж талбай камержуулалт

## СУМЫН ТӨСӨВ

**48.6**
Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагын тоног төхөөрөмж /Цагдаагийн газар/

**100.0**
Чойбалсан хотын усан хангамжийн шугам хоолойд усны чанар сайжруулах тоног төхөөрөмж суурилуулах

**6.0**
Тоног төхөөрөмж сайжруулах /Улсын бүртгэлийн хэлтэс/

**6.5**
Тоног төхөөрөмж сайжруулах /Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс/

**20.0**
Тоног төхөөрөмж сайжруулах /Татварын хэлтэс/

**20.0**
Суманд 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын барилга, байгууламж, их засварын ажлын зураг төсвийн зардал

## БУСАД ЭХ ҮҮСВЭР

**25.0**
Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд бүх нийтээр мод тарих аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийн зардал

**3.0**
Ойн нөхөрлөлүүдийн ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, хэрэгжилтэд зөвлөн туслах ажилд дэмжлэг

**78.8**
Ойн зурвасын хашаа хийх ажил (Хэрлэн сум)

**18.0**
Нэн ховор, ховор амьтныг хамгаалах арга хэмжээний хүрээнд цагаан зээр, саарал чоно хамгаалах ажлыг үргэлжлүүлэх

**5.0**
Дорнод Монголын хээр талыг дэлхийн өвд авах ажлын хүрээнд Улсын тусгай хамгаалалттай байгалийн нөөц газруудад судалгаа хийх, хилийн цэсийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах

**15.0**
Амьтны амьдрах орчныг сайжруулах зорилгоор ажиглалт, тандалт судалгаа, мониторинг хийх, биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажлын зардал

## СУМЫН ТӨСӨВ

**5.0**
Баяр наадмын зардал

**30.0**
Малчин болон мал бүхий иргэдийн малыг ундны усаар хангах /Нүүлгэн шилжүүлсэн, 5 дугаар баг/

**70.0**
Малчин болон мал бүхий иргэдийг цахилгаан эрчим хүчээр хангах /Нүүлгэн шилжүүлсэн/

**103.4**
Ламжавын гудамжны авто замын засвар /Хэрлэн сумын 2, 3-р баг/

**996.8**
Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт

**198.0**
Авто замын засвар арчлалтын техник, тоног төхөөрөмж

**719.5**
"Арван мянган хүлэмж" төсөл

**110.0**
Гүн өрмийн худгийн цооног гаргах

**57.8**
Эрсдэлийн зардал

**80.0**
Чойбалсан хот орчмын эвдэрсэн газруудад нөхөн сэргээлт хийх

**50.0**
Байгаль орчинд учруулсан хохирлыг тогтоох үнэлгээ хийх зардал

**58.0**
Нийтийн эзэмшлийн гудамж талбайд хэрсийг доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр зүлэгжүүлэлт хийхэд шаардлагатай бараа материал

**152.0**
Гадаргын усны нөөц хамгаалах, хиймэл нуурын арчлалт, усны тэжээгдлийг сайжруулах ажил

**15.0**
Худаг, усны тоо бүртгэл явуулж, усны мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах зардал

**15.0**
Хур бороо нэмэгдүүлэх зорилгоор үүлэнд зориудаар нөлөөлөх

**30.0**
Мод тарих, ногоон байгууламжийн усалгаанд шаардагдах  цооног гаргах

**30.0**
Улсын тусгай хамгаалалттай Байгалийн нөөц газрууд, орон нутгийн тусгай хамгаалалттай газарт тэмдэг тэмдэглэгээ хийх зардал

**5.0**
Ус ашиглагч аж ахуйн нэгжүүдийн ус ашиглалт, усны нөөцийг хамгаалах ажилд хяналт тавих

**33.8**
АДАПТ төсөлтэй хамтран "Булгийн эхийг хашиж, хамгаалах" ажлын орон нутгийн төсвөөс гаргах 30 хувь

**236.3**
АДАПТ төсөлтэй хамтран "Хэрлэн, Улз голын татмын ойг нэмэгдүүлэх, нөхөн сэргээх, ойжуулалт хийх (105 га)"  ажлын орон нутгийн төсвөөс гаргах 30 хувь

**10.0**
Хэрлэн голыг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах.

**40.0**
Ойн хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх

**60.0**
Түймэрт шатсан, хөнөөлт шавжид нэрвэгдсэн, мод бэлтгэсэн 50 га талбайд ойжуулалт хийх ажил

**30.0**
Хилийн зурвасын дагуу ой, хээрийн түймрээс хамгаалах шороон зурвасыг сэргээх

**250.0**
Иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр бойжуулсан чанартай тарьц, суулгацыг худалдан авч иргэн аж ахуйн нэгж байгууллагад нийлүүлэх, "Жимсний мод тариалъя" төсөл хэрэгжүүлэх

## СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)

| Нийт | ОНХС | Малын тоо толгойн албан татвар | Урд оны үлдэгдэл | Уул уурхайн хандив, тусламж | Бусад |
|---|---|---|---|---|---|
| 2,429.7 | 2,101.6 | 100.0 | 228.1 | - | |

## СУМЫН ОНХС

| Дүн | Арга хэмжээ |
|---|---|
| 20.5 | Хотын доторх зам засварлах / Явган зам/ |
| 27.9 | Тоглоомын талбай байгуулах, орчны тохижилт / 2 дугаар баг / |
| 22.0 | Эгнээ гудамжнууд дундуур явган хүн зорчих хэсгийн замыг сайжруулах хатуу хучилттай болгох / 4 дүгээр баг/ |
| 44.5 | Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх |
| 31.5 | Авто зогсоол байгуулах /12 дугаар цэцэрлэг/ |
| 100.0 | Хотын нийтийн эзэмшлийн гудамж талбайн зүлэгжүүлэлт, ногоон байгууламж нэмэгдүүлэх |
| 123.9 | Орон сууцны 22,23 дугаар байрны гадна талбайн тохижилт |
| 100.0 | Орон сууцны байруудын гадна тохижилт /7 дугаар баг/ |
| 100.0 | Орон сууцны байруудын гадна тохижилт /8 дугаар баг/ |
| 250.4 | Явган зам шинээр байгуулах |
| 129.3 | Орон сууцны байруудын гадна тохижилт /9 дүгээр баг/ |
| 600.0 | Ахлах сургуулийн барилгын их засвар /Шинэ хөгжил цогцолбор сургууль/ |
| 179.2 | Орон сууцны орцны хаалга шинэчлэн засварлах / 6,9 дүгээр баг/ |
| 30.3 | Төв зам дагуух гэрэлтүүлэг / 1 дүгээр баг/ |
| 64.7 | Цэцэрлэгийн барилгын дотор засвар /14 дүгээр цэцэрлэг / |
| 90.0 | Гэр хорооллын эгнээнд гудамжны гэрэлтүүлэг / 4 дүгээр баг/ |
| 100.0 | Гэр хорооллын эгнээнд гудамжны гэрэлтүүлэг / 11 дүгээр баг/ |
| 90.7 | Төв зам дагуух гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх /3 дугаар баг/ |
| 200.0 | Хогны машин худалдан авах / 2 ширхэг/ |
| 20.0 | Суманд 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын барилга, байгууламж, их засварын ажлын зураг төсвийн зардал |

## БАЯНДУН СУМ

1925 оны хавар одоогийн Баян-Уул сумын нутаг Уртын голд Баян-Уул, Хужиртаан, Бүс, Салхит зэрэг газраар нутаглаж байсан ардын хурал болж, тэр үеийн Алхана, Онон-Ага сумдын зарим хэсэг, аль ч суманд харъяалалгүй байсан нутгийн ардуудаас бүрдсэн “Шинэ Алхана” сумыг 9 баг, 192 өрхтэйгөөр байгуулж сумын даргаар Д.Дашдондог (Тогоон), нарийн бичгийн даргаар Д.Дамбаренчин нарыг сонгож, нутгийн төв хэсэг нь Салхит, Бүсийн гол, Билүүт зэрэг газар болж байв. Ингэж шинээр байгуулагдсан энэ сумыг одоогийн “Баяндун” сумын гал голомт гэж үздэг. Орон нутгийн захиргааны дүрмийн 33 дугаар зүйлийн заалтыг үндэс болгон, Оросын нутагт байсан уулын нэрээр нэршсэн “Шинэ Алхана” сум гэдэг нэрийг өөрчлөн нутгийн уулын нэрээр “Баяндун уулын сум” гэж нэрлэх болсон байна. Сумын төв Наранбулаг аймгийн төв Чойбалсангаас 176 км, улсын нийслэл Улаанбаатараас 669 км зайнд байна.

**6.235 км2 газар нутагтай.**




**СУМЫН ТӨСӨВ (сая төгрөг)**



## НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (сая.төг)




## УЛСЫН ТӨСӨВ

**1,564.0**
Сургуулийн барилга, урлаг заал

## АЙМГИЙН ТӨСӨВ

**27.0**
Онцгой байдлын үед хэрэглэх хадлан, өвс тэжээлийн агуулах 2 суманд барих

## АЙМГИЙН ОНХС

**20.0**
Автомашин болон ковш засвар

**62.0**
Ариун цэврийн байгууламж

## СУМЫН ТӨСӨВ

**6.5**
Засаг даргын тамгын газрын дотоод засвар, тохижилт

**51.0**
Засаг даргын тамгын газрын барилгын халаалтын системийг шинэчлэх

**6.5**
Засаг даргын тамгын газрын тоног төхөөрөмж

**143.0**
"Мянган зоорь" төслийн хүрээнд зоорийн засвар

**38.0**
Эрүүл мэндийн төвийн халаалтын тогооны засвар

## СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)

| Нийт | ОНХС | Малын тоо толгойн албан татвар | Урд оны үлдэгдэл | Уул уурхайн хандив, тусламж | Бусад |
|---|---|---|---|---|---|
| 1,031.3 | 767.7 | 82.0 | 46.8 | - | 134.8 |

## СУМЫН ОНХС

**26.7**
Цэцэрлэгийн анги, бүлгүүдийн орчны тохижилт

**18.0**
Халаалтын тогоо солих /ЕБС/

**19.0**
Гадна тохижилт болон засвар /ЕБС/

**16.0**
Цахим анги /ЕБС/

**27.4**
Гадаад хэлний лингафоны танхим байгуулах /ЕБС/

**27.0**
АДАПТ төсөлтэй хамтран “Онцгой байдлын үед хэрэглэх хадлан, өвс тэжээлийн агуулах барих

**41.0**
Хэт авианы аппарат /ЭМТ/

**20.0**
Гадна тохижилт /ЭМТ/

**15.0**
Угтамын рашаан сувилалын тохижилт

**20.0**
Дэд бүтэц сайжруулах

**20.0**
Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, арчилгаа

**19.9**
Соёлын төвийн засвар

**45.9**
Соёлын дэд хөтөлбөр

**147.0**
Хог хаягдлын байгууламж

**20.0**
Наранбулагийн гарам засварлах

**30.0**
Худаг гаргах

**70.6**
Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт

**30.0**
Наранбулаг хөгжил ОНӨААТҮГ-ын үйл ажилгааг дэмжих

## СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)




## СУМЫН ОНХС

**48.6**
Замын засвар /он дамжсан/

**38.0**
Хүүхдийн цэцэрлэгийн халаалтын тогоо солих /он дамжсан /

**32.6**
Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт /он дамжсан/

## БУСАД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

**40.0**
Малын угаалгын ванн

**30.0**
Нэг сум, нэг үүлдэр

**5.0**
Нэг сум, нэг малчин зөвлөгөөн зохион байгуулах

**5.0**
Малын хулгайтай тэмцэх

**2.0**
Мал тооллогын зардал

## БАЯНТҮМЭН СУМ

Баянтүмэн сум нь 1959 онд байгуулагдсан. Баян, Хөдөлмөр хоёр нэгдэл бүх гишүүдийн санал асуулга явуулж 1957 оны 11-р сард хоёр нэгдэл нэгдэж даргаар нь Хөдөлмөр нэгдлийн дарга Санжмятавын Батмөнхийг, орлогч даргаар нь Амьтаны Амгалан нарыг сонгож нэгдлийнхээ нэрийг "Баясгалант хөдөлмөр" гэж тогтон хоёр талаасаа оролцуулан нэгдлийн ерөнхий хорооны гишүүдийг 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр сонгосон байна.

1959 оны 4 сарын 15-нд Баянтүмэн сум байгуулахаар Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн зарлиг гарч уг зарлигийг үндэслэн аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны даргын захирамжаар Баянтүмэн сумын АДХ-ын гүйцэтгэх захиргааны даргаар Баясгалант хөдөлмөр нэгдлийн дарга С.Батмөнхийг, орлогч даргаар хорины дарга Л.Жигмэд, нарийн бичгийн даргаар Арав жаргалант суманд ажиллаж байсан Жамбын Өлзийхутаг нарыг томилжээ. Тус сумын 4 дүгээр багийн Хотонт нуурын орчим "Тосон хулстай" нь байгалийн нөөц газарт хамрагдсан бөгөөд Хутаг уул, Булган овоо, Буяндэлгэр овоо, Очиртын овоо, Халхын таван уул, Жамъянгүний овоог орон нутгийн тусгай хамгаалалтад авсан.

**8.321 км2 газар нутагтай.**




**СУМЫН ТӨСӨВ (сая төгрөг)**



## НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (сая.төг)




## УЛСЫН ТӨСӨВ



**51.6**
Цэцэрлэгийн барилга, 150 ор



**347.0**
Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 20 ор

## АЙМГИЙН ОНХС



**220.0**
Чойбалсан хотын төв хогийн цэгийн цахилгаан дамжуулах шугам, дэд станц, гүний худаг

## АЙМГИЙН ТӨСӨВ



**45.0**
Соёлын төвийн дээврийн засвар



**9.0**
"Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор инженерийн хийцтэй худаг гаргах, сэргээн засварлах"



**50.0**
Боловсролын болон спортын зарим байгууллагын албан хэрэгцээнд зөөврийн компьютер

## СУМЫН ТӨСӨВ



**3.0**
Бэлчээрийн фотомониторинг хийх



**0.5**
уул овоо тахилга



**0.3**
Цэрэг татлага



**0.8**
Гэр бүл хөгжил дэвшил дэд хөтөлбөр



**3.0**
Нохой устгал

## СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)




## СУМЫН ОНХС

**60.0**
Нэгдсэн халаалтын зураг төсөв

**6.1**
Хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөв

**35.0**
Шүдний борын машин

**65.0**
Соёлын төвийн их засвар

**20.0**
Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн засвар

**85.0**
Сумын төвийн цахилгааны хүчин чадлыг өргөтгөх, дэд станц тавих

**75.5**
Сургуулийн халаалтын тогооны засвар шинэчлэлт

**65.0**
Тэрбум модны хүрээнд хашаажуулалт

**10.0**
Тэрбум модны хүрээнд модны суулгац

**40.0**
Сургуулийн компьтерийн кабнет

**20.0**
Төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй ил тод байдлыг хангах

**20.0**
Худгийн цооног Уйлантын салаа /2 дугаар баг/

**6.0**
Иргэний бүртгэлийн киоск машин

**7.0**
Сургуулийн тогооны засвар

**5.0**
Үндэсний баяр наадмын зардал

**65.7**
Баянтүмэн хөгжил ОНӨААТҮГ /орчны тохижилт, арчлалт, үйлчилгээний төсөл/

**3.0**
Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх хөтөлбөр

**5.0**
Залуучууд, эмэгтэйчүүдийг дэмжих хөтөлбөр

**6.0**
Өв соёл хөтөлбөр /Соёлын төв/

**8.9**
Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтийн тээврийн үйлчилгээ

## СУМЫН ОНХС

**3.5**
Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих хөтөлбөрийн үйл ажиллагаа

**10.0**
Гамшгаас хамгаалах зардал

**5.0**
Миний ном, номын сангийн баяжилт

**10.0**
Сургалтын хэрэглэгдэхүүн

**10.0**
Гэмт халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх тэмцэх

**3.0**
Манлай малчин хөтөлбөр

**6.0**
Хүн болох багаасаа хөтөлбөр /хуураар хөглөгдөх/

## БУСАД ЭХ ҮҮСВЭР

**42.0**
Малын эрүүл мэндийг хамгаалах /мал эмнэлгийн байрны халаалт/ 1-р баг

**20.0**
Бэлчээрийн менежмент сайжруулах төлөвлөгөө боловсруулах

**20.0**
Мал угаалгын ванн Зүүн гол

**20.0**
Мал угаалгын ванн Хадат

**20.0**
Гүн өрмийн худгийн цооног Хадат

**20.0**
Гүн өрмийн худгийн цооног Гурваны булаг

**20.0**
Гүн өрмийн худгийн цооног Завсрын бууц

**50.0**
Гамшигаас хамгаалах бэлэн байдлыг хангах болон тусгай чиг үүргийн албан хэрэгцээнд

**20.0**
Гамшгаас хамгаалах хяналтын постны зөөврийн сууц

**9.0**
Адапт төсөлтэй хамтран "Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор худаг гаргах"

**21.0**
Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын зардал

**10.0**
Хортон мэрэгчтэй тэмцэх арга хэмжээ

**3.1**
Хамтарсан хяналт шалгалт, идэвхтэн байгаль хамгаалагч, мод арчилгааны зардал

**2.7**
Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих /хяналтын зардал/

**89.0**
Зээл олголт

## БАЯН-УУЛ СУМ

Баян-Уул сум нь анх 1922 онд “Алхана сум” (дарга нь Д.Дондог) нэртэйгээр байгуулагджээ. 1925 онд зарим буриад сумдын нэрийг хуучин хойт нутагт байсан нэрээр нэрлэж байсныг болиулж, өөрийн нутаглаж байсан газрынх нь нэрээр нэрлэх болсноор “Алхана” гэж нэрлэгдэж байсан энэ сум Баян Хан уулын сум (дарга нь Ц.Равдан) болж, эдүгээгийн тус сумын нутаг Эрдэнийн булаг, Доод Наанги, Баадай хөндий зэрэг газраар нүүдэллэн төвлөж байв. 1929 оны үед одоогийн Баяндун сумын Өвгөд уулнаас баруун тийш Улз голын дагуух суманд Бумбат, Дэлгэр уул, Баянзүрх, Паршин сумд нийлж “Тариалан сум” гэж нэрлэгдэх болсон байна. 1932 онд “Шинэ эргэлтийн бодлого”-ын заалтыг үндэслэн Тариалан сумыг дахин Баян-Уул (дарга нь Ц.Галдан, нарийн бичгийн дарга нь П.Цэвээн) гэж нэрлэж, одоогийн сумын төв Жаварт хошуунд төвлөрүүлжээ. Орос улстай хиллэдэг. Сумын төв Жаварт Хошуу нь аймгийн төв Чойбалсангаас баруун хойш 200 км зайд, Улз голын эрэгт оршино. Сумын төвөөс баруун хойш 26 км зайд Эрээн тосгон бий.

**5.623 км2 газар нутагтай.**




**СУМЫН ТӨСӨВ (сая төгрөг)**



## НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (сая.төг)

| Нийт | Улсын төсөв | Аймгийн төсөв | Сумын төсөв | Аймгийн ОНХС | Сумын ОНХС | Бусад |
|---|---|---|---|---|---|---|
| 30,064.7 | 28,758.6 | 79.1 | 159.3 | 75.0 | 992.7 | |

## УЛСЫН ТӨСӨВ

**1,829.0**
Дотуур байрны барилга, 160 ор

**21,856.7**
Норовлин сумаас Баян-Уул чиглэлийн хатуу хучилттай авто зам, 68.3

**5,000.0**
Баян-Уул сумаас Ульхан боомт хүртэлх хатуу хучилттай авто зам, 50

**72.9**
Соёлын төвийн барилга, 250 суудал /Дорнод, Баян-Уул сум/

## АЙМГИЙН ТӨСӨВ

**60.0**
Цагдаагийн тасгийн барилгын өргөтгөл, засвар

**19.1**
Ерөнхий боловсролын сургуулийн тоног төхөөрөмж, тохижилт

## АЙМГИЙН ОНХС

**75.0**
Цахилгаан эрчим хүчний дэд станц

## СУМЫН ТӨСӨВ

**5.0**
Хөтөлбөр арга хэмжээний зардал

**8.0**
Цагдаагийн үйл ажиллагааны зардал

**0.8**
Цэрэг татлага

**3.0**
Цагаан сарын үйл ажиллагаа

**4.0**
ГТУА 53-р ангийн гамшгаас урьдчилан сэргийлэх үйл

**1.0**
Баян Уулын тахилга үйл ажиллагааны зардал

**1.0**
Хил хамгаалах туслах хүчний гишүүдэд түймэр унтраах багаж хэрэгсэл

**2.0**
Ахмадын үйл ажиллагааны зардал

**2.0**
Залуучуудын үйл ажиллагааны зардал

**5.0**
Улс, олон улсын тэмцээн уралдааны урамшуулал, дэмжлэг

## СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)




## СУМЫН ТӨСӨВ

**10.0**
Улсын Баяр наадмын зардал

**20.0**
Биеийн тамир уралдаан тэмцээний зардал

**15.0**
Сумын 100 жилийн ойн бэлтгэл ажлын хүрээний үйл ажиллагааны зардал

**2.0**
ГХУССЗөвлөлийн үйл ажиллагааны зардал

**2.5**
Мал тооллого

**1.0**
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгааллын хөтөлбөр

**10.0**
ЗДТГазрын мэдээлэл суртчилгааны тоног төхөөрөмж

**7.0**
Онцгой байдлын 53-р ангийн орон сууцны дэмжлэг

**60.0**
Цагдаагийн тасгийн барилгын өргөтгөл, засвар

## СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)




## СУМЫН ОНХС

**10.0**
ОНХС-ын хөрөнгөөр хийгдсэн нийтийн эзэмшлийн барилга байгууламжийн засвар

**10.0**
Сумын төвийн гэрэлтүүлэг засварлах

**100.0**
Наадмын талбайн тохижилт урсгал засвар

**40.0**
Нутгийн иргэдийн ордны гадна, дотор засвар

**15.0**
"Тэрбум мод" хөдөлгөөний хүрээнд хашаажуулалт хийх

**10.0**
"Тэрбум мод" хөдөлгөөний хүрээнд нарс модны боргоцой, тарьц авах

**34.7**
Ундны усны худагт цэвэршүүлэх тоног төхөөрөмж суурьшуулах

**20.0**
Сумын төвийн зам засвар 4 , 5 баг

**30.0**
Ерөнхий боловсролын сургуулийн барилгын дотор халаалтын радиатор, шугам слих, засварлах

**160.0**
Спорт тоглоомын талбайн тохижилт хийх

**20.0**
Нийтийн хогийн цэгийг хашаажуулах

**20.0**
ЕБСургуулийн барилгын урсгал засвар

**30.0**
Замын зураг төсөв

**15.0**
Улзын Хөгжил ОНӨААТҮГазарт дэмжлэг

**22.0**
Байгаль орчны хог хаягдал цэвэрлэх, нохой устгал

**33.9**
Цэцэрлэгийн халаалтын радиатор солих

**1.5**
Цэцэрлэгт ууриин индүү, угаалгын машин

**95.0**
Сумын Онцгой комисс, Шуурхай штабын тусгаарлах байрны засвар

**20.0**
Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-2

**15.0**
Орон нутаг судлах танхимын тохижолт

## СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)

| Нийт | ОНХС | Малын тоо толгойн албан татвар | Урд оны үлдэгдэл | Уул уурхайн хандив, тусламж | Бусад |
|---|---|---|---|---|---|
| 992.6 | 797.1 | 181.5 | 14.0 | - | - |

## СУМЫН ОНХС

- **5.0** Улсын баяр наадам
- **20.0** Хүн болох багаасаа хүүхдийн гадаад хэлний сургалтын тоног төхөөрөмж
- **10.0** Эрээн давааны зам засвар
- **20.0** Авто замын засварын тоног төхөөрөмжийн ажлын хөлс
- **40.0** ЭМТ-ийн барилгын урсгал засвар
- **110.0** Худаг, уст цэг нэмэгдүүлэх
- **20.0** Малын үүлдэр угсаа сайжруулах
- **20.0** Гамшгаас хамгаалах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нэмэгдүүлэх
- **4.3** ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөн сургалт, сурталчилгаа
- **6.0** Малын сэг зэм устгах, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх , тандалт хяналт хийх
- **0.7** Бэлчээрийн газрын өөрчлөлтийн судалгаа хийх /фото мониторонг/
- **1.5** Бэлчээрийн доройтлоос сэргийлэх, хортон мэрэгчдээс хамгаалах, сургалт сурталчилгаа
- **1.0** "Нэг өрх , Нэг зүү"хэрэгжилтыг хангуулах
- **5.0** Буриад омгийн үүлдэр угсааг баталгаажуулах
- **5.0** Малын халдваргүйтгэлийн бодис худалдан авах
- **2.0** Малын эмэгжүүлэлт
- **10.0** TNC олон улсын байгууллагатай хамтарч төсөл хэрэгжүүлэх
- **10.0** Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдэд дэмжлэг үзүүлэх

## БУЛГАН СУМ

Ардын Засгийн газрын 1923 оны 10-р сарын 23-ны өдрийн 32-р тогтоолоор хуучин засаг захиргааны нэгжийг өөрчлөн байгуулахад Баруун их сумын суурин дээр Хан Хэнтий уулын аймгийн Баянтүмэн Хан-уулын хошууны "Баян Булган" сум 1931 онд үүсэн байгуулагджээ. Дорнод аймаг 1931 онд анх 24 сумтай байгуулагдахад 13 багтай, 700 гаруй өрхтэй, 1500 хүн амтай 80 мянган малтай "Шинэ Булган" сум зохион байгуулсан түүхтэй.

Тус сум нь зүүн хойд, зүүн талаараа Баянтүмэн сум, зүүн урдуураа Матад, урдуураа Сүхбаатар аймгийн Сүхбаатар сум, баруун талаараа Хөлөнбуйр, баруун хойгуураа Цагаан-овоо сумтай тус тус хиллэдэг. Нийслэл Улаанбаатар хотоос 600, аймгийн төв Чойбалсан хотоос 50 км зайтай. Сумын төв Өндөр хошуу. Дорнод аймгийн төв Чойбалсангаас 50 км, улсын нийслэл Улаанбаатараас 600 км зайтай.

**7.111 км2 газар нутагтай.**




**СУМЫН ТӨСӨВ (сая төгрөг)**



## НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (сая.төг)

| Нийт | Улсын төсөв | Аймгийн төсөв | Сумын төсөв | Аймгийн ОНХС | Сумын ОНХС | Бусад |
|---|---|---|---|---|---|---|
| 1,052.9 | - | 191.2 | 30.0 | 231.0 | 593.7 | 7.0 |

## АЙМГИЙН ТӨСӨВ

**191.2**
Эхийн амрах байр

## АЙМГИЙН ОНХС

**91.0**
Цэцэрлэгийн барилгын дээврийн засвар

**80.0**
Эрүүл мэндийн төвийн засвар

**60.0**
Цахилгаан дамжуулах агаарын шугам /Булган сум/

## СУМЫН ТӨСӨВ

**1.0**
“Малчин түмний баяр”

**2.0**
Сумын аварга сайн малчин шилдгүүдийн шагнал

**1.0**
Ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх

**0.5**
“Ахмадын баяр”-ын үйл ажиллагаа

**3.0**
Жилийн эцсийн мал тооллогын зардал

**0.5**
Цэрэг татлагын зардал

**1.0**
“Оны 9 алдартан” шалгаруулах

**0.5**
Цаг уурын Масс мэдээ үйлчилгээ

**1.0**
“Ахмад настны урлаг спортын бага наадам”-ыг дэмжих

**2.0**
Золбин нохой устгах

**0.5**
Татвар төлөгчдийн өдөрлөг

**5.1**
Биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах, орон нутаг болон бүсийн чанартай уралдаан тэмцээнд дэмжлэг үзүүлэх

**5.0**
Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал

**6.5**
Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх

**0.4**
А-3 сургалт зардал

## СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)




## СУМЫН ОНХС

**5.0** Угаалгын ванн шинээр барих /Баян-уул багт/

**20.0** Сургуулийн биеийн тамирын талбайтай болох

**53.7** Хүүхэд залуучуудын талбайг тохижуулах

**20.0** Волейболын талбайг засварлах

**20.0** Сагсны талбайг засварлах

**5.0** Наадмын талбайн урсгал засвар

**5.0** Баяр наадмын зардал

**20.0** Цэцэрлэгт хүрээлэн тохижуулах

**20.0** Цэцэрлэгт хүрээлэн гэрэлтүүлэг

**20.0** Хогийн цэг хашаажуулах

**17.8** Нийтийн эзэмшлийн урсгал засвар

**23.3** Ахуйн үйлчилгээний төвийн халаалтын тогоог шинэчлэх

**40.0** Багшийн үйл ажиллагааг дэмжих

**22.0** Гэр цэцэрлэг тохижуулах

**15.0** Наадмын асар майхан

**46.0** ЭМТ-ийн халаалтын тогоог шинэчлэх

**34.0** Цахилгаан дамжуулах шугам дэд станц

**15.0** Сумын төвийн цахилгаан дамжуулах модон тулгуур солих

**20.0** Ногооны талбай хашаажуулалт

**20.0** Иргэдийн мэдээллийн цэгийн тохижилт

## СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)




## СУМЫН ОНХС

**5.0**
Гамшгаас хамгаалах зардал

**10.0**
Баян-Уул багийн төвийн засвар

**12.0**
Соёлын төвийн техник хэрэгсэл нэмэгдүүлэх

**5.0**
2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын

**48.0**
Ангилалтын хашаа/Баян-Уул,Их цагаан нуур,Жавхлант бүлэг/

**18.0**
Худгийн цооног/Хулсан шанд багт/

**6.0**
Бэлчээрийн менежментийг сайжруулах

**20.0**
Угаалгын ванн /Хулсан шанд баг/

**7.0**
Эцэг малын эзэмгжүүлэлт

**5.0**
Угаалгын ванн /Чулуут баг/

**9.0**
Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардал

**7.0**
Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа

## БУСАД ҮҮСВЭР

**7.0**
Хогийн цэгийн далан сэргээх

## ГУРВАНЗАГАЛ СУМ

Богд хаан болон Ардын засгийн газраас Манлай баатар Дамдинсүрэнгийн хүсэлтийг үндэс болгон Сэцэн хан аймгийн Ачит бэйсийн зүүн хойт хэсэг газар болон Ар таван харуулын нутгийг түүнд олгосноор Өвөрмонголын Хөлөнбуйр аймгаас 1917 онд нүүдэллэн Монголд орж ирсэн барга ардуудын эзэмшил нутаг болж 1923 онд Амгалан хан уулын хошуу (захирагч нь Дамдинсүрэнгийн их хүү Долцон ван) байгуулагдсан байна.

Сумын нутагт хэрмэн зам буюу Чингисийн далан, Цагаан чулуут, Хадан хөвийн дөрвөлжин булш, Хөцөөгийн хоолойн зурагт хад, Манлайбаатар Дамдинсүрэнгийн хөшөө зэрэг түүхийн дурсгалт газрууд бий. Гурванзагал сум нь аймгийн төвөөс 126 км-т Онон-Улзын хээрийн бүсийн тойрогт багтах Сүмийн булаг хэмээх газар оршино. Сум нь зүүн хойд талаараа Чулуунхороот сум, хойд талаараа Дашбалбар сум, баруун талаараа Сэргэлэн сум, урд талаараа Чойбалсан сумтай тус тус хил залгаж оршино.

**5.252 км2 газар нутагтай.**




**СУМЫН ТӨСӨВ (сая төгрөг)**



## НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (сая.төг)




## УЛСЫН ТӨСӨВ

**82.0**
Соёлын төвийн барилга, 250 суудал

## АЙМГИЙН ТӨСӨВ

**292.9**
Сумдад нэн хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдад зориулсан орон сууцны барилга

**6.0**
"Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор инженерийн хийцтэй худаг гаргах, сэргээн засварлах"

**43.2**
Ерөнхий боловсролын сургуулийн тоног төхөөрөмж, тохижилт

## АЙМГИЙН ОНХС

**18.0**
Хөгжлийн төлөвлөгөө батлуулах

**50.0**
Соёлын төвийн тохижилт

## СУМЫН ТӨСӨВ

**235.0**
Мал төхөөрөх бага оврын үйлдвэрийн барилга барих

**151.7**
Ерөнхий боловсролын сургуулийн гадна сагсны сагсны талбай байгуулах

**4.5**
Соёлын төвийн гадна гэрэлтүүлэг хийх

**17.0**
Соёлын төвд тоног төхөөрөмж худалдан авах

**19.0**
Эрүүл мэндийн төвд зөөврийн ЭХО аппарат худалдан авах

**8.1**
Цэцэрлэгт гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах

**50.0**
Төрийн албан хаагчдыг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах

**15.0**
Сумын түүхэн ном шинээр гаргах

**85.0**
Ковш худалдан авах

## СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)

| Нийт | ОНХС | Малын тоо толгойн албан татвар | Урд оны үлдэгдэл | Уул уурхайн хандив, тусламж | Бусад |
|---|---|---|---|---|---|
| 524.3 | 277.7 | 110.0 | 126.3 | - | 10.3 |

## СУМЫН ОНХС

**31.3**
“Манлайбаатар” Ж.Дамдинсүрэнгийн нэрэмжит төв талбай байгуулах

**1.0**
Их эмчийн байрны засвар

**94.0**
Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй орон нутгийн өмчийн орон сууцны барилга шинээр барих ажилд дэмжлэг

**5.0**
Улсын баяр наадам тэмдэглэх

**20.0**
Ундны усны худгийн байр шинээр барих

**13.5**
Ундны усны худагт цэвэршүүлэх төхөөрөмж, ухаалаг систем тавих

**215.4**
Төвлөрсөн хогны цэгийг дарж булах, цэгцлэх ажлыг зохион байгуулах

**11.7**
Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн дотуур байрны камержуулалт

**12.1**
Хүүхдийн цэцэрлэгийн камержуулалт

**5.0**
Мал эмнэлгийн ариутгал халдваргүйтгэлийн тоног төхөөрөмж худалдан авах

**20.0**
Сэг зэм устгалын цэг шинээр байгуулах /Рашаант, Цагаанхошуу багт/

**40.0**
Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх гүн өрмийн худгийн цооног гаргах

**10.0**
Аюулгүй нөөцөд хивэг, тэжээлийн бүрдүүлэх

**5.0**
Хуц, ухны ангилалт хийх

**6.0**
АДАПТ төсөлтэй хамтран “Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор инженерийн хийцтэй 2 худаг гаргах” ажлын сумаас гаргах 15 хувь (Аймгаас 15%, АДАПТ төслөөс 70%)

**20.0**
Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал

**4.0**
Малчдад зориулсан сургалт, зөвлөгөөн

## БУСАД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

**7.7**
Ногооны талбай болон ногоон байгууламжийн хашаа шинэчлэн засварлах

**2.6**
“ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөний хүрээнд модны тарьц, суулгац авах

## ДАШБАЛБАР СУМ

Дашбалбар сумын нутагт 1922-1923 онд Далай сум, Хөх уул сум, Баруун Тарь сум, Улз сум байсан бол Улз голын хошуу байгуулагдсанаас хойш орон нутгийн засаг захиргааны өөрчлөлтүүд хэд дахин хийгдэж 1925 оны эхэн үед Эрхэт баян сум, Дашбалбар сум, Хөх уул сум, Улз сум, Баруун Тарь сум, Далай сум болж Улз сум Улз голоор, Баруун Тарь сум Улз ба Дөч голын цутгал хавиар, Далай сум Дөч голын саваар, Хөх уул сум Хөх уулын ар өвөр, Ямалхын голоор тус тус нутаглаж байв. 1926 онд Улз ба Далай сум хоёр нийлж Дашбалбар сум болов. 1929 он болоход Баруун Тарь, Дашбалбар хоёр сум нийлж Дашбалбар сум, Хөх уул ба Эрхэт баян хоёр нийлж Хөх уул сум болов. 1931 онд Дашбалбар ба Хөх уул сум хоёр нийлж Дашбалбар сум болжээ. Сумын хүн амын 30 гаруй хувь нь Цагаан дэв гэдэг газар орших төвдөө амьдардаг.

**8.713 км2 газар нутагтай.**




**СУМЫН ТӨСӨВ (сая төгрөг)**



## НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (сая.төг)




## УЛСЫН ТӨСӨВ

**4,681.6**
Дашбалбар сумын цахилгаан хангамжийн 35 кВ-ын цахилгаан

## АЙМГИЙН ТӨСӨВ

**90.0**
Сэвсүүлийн голын гарам, хоолой

## АЙМГИЙН ОНХС

**100.0**
Цахилгаан дамжуулах агаарын шугам

## СУМЫН ТӨСӨВ

**33.9**
Сумын ЗДТГ-ын барилгын засварын ажил

**25.4**
ЦДАШ-ын угсралтын ажил

**3.0**
Газан халаагуур

**6.5**
Гал түймрийн аюулаас сэргийлэх үлээгч

**15.0**
Харзат гол гарам

**15.0**
Цагаан хөндийн гарам

**11.0**
Соёлын төвийн зөөврийн тоног төхөөрөмж

**20.0**
ЭМТ-ийн уламжлалт эмчилгээний аппарат

**51.8**
Зураг төсөв боловсруулах зардал

**2.0**
багш сурагчдыг урамшуулах

**30.0**
Биеийн тамир спортыг хөгжүүлэх

**3.0**
Цагаан сарын үйл ажиллагаа

**15.0**
Баяр наадмын үйл ажиллагаа

**7.0**
Нохойг бүртгэлжүүлэх, нөхөн үржхүйг хязгаарлах

**3.0**
Жилийн эцсийн мал тооллогын зардал

## НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (сая.төг)




## СУМЫН ТӨСӨВ

**28.0**
Оюутанд сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх

**7.0**
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал

**20.0**
Сумын аюулгүй нөөцийн өвс, тэжээл бэлтгэх зардал

**6.0**
Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих

**2.0**
Сум сурталчлах зардал

**20.0**
Гэрэлтүүлэг дэд хөтөлбөр

**20.0**
Нийтийн эзэмшлийн байгууламж, талбайн арчилгаа, засвар

**20.0**
Ахуйн хог хаягдлын менежмент сайжруулах

**6.0**
Соёл дэд хөтөлбөр

**5.0**
Ухаалаг самбар

**5.3**
Тоглонгоо суралцах бидний орчин хөтөлбөр

**0.6**
Үл хөдлөх хөрөнгө дурсгалт газрын хаягжуулалт

**12.0**
Өмгөөллийн үйлчилгээний хөлс

## СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)




## СУМЫН ОНХС

**208.7**
Буриадын өв соёлын музей, номын сангийн барилга

**850.0**
Монгол Улсын Засгийн газрын шинэ сэргэлтийн бодлогын хөдөөний хөгжлийг дэмжих ажлын хүрээнд Төрийн албан хаагчдын орон сууц барих

**19.0**
Хогийн цэгийн манаачийн байр нүүлгэн шилжүүлэх ажил

**68.5**
Хогийн цэгийн гадна цахилгаан хангамжийн угсралтын ажил

**4.7**
Хог ангилах байрны дотор гэрэлтүүлгийн ажил

**2.6**
Хогийн цэгийн камержуулалт

**120.0**
Хүүхдийн тоглоомын талбай

**360.0**
Улз голын гүүрний далангийн ажил

**250.0**
Бага сургуулийн барилгын хэсэгчилсэн засвар

**90.0**
Сумын төвийн шороон зам сайжруулах

**5.0**
Баяр наадмын зардал

**20.0**
Жудо бөх дэвжээ

**15.0**
Жараахай голын гарам

**6.0**
Булаг хаших

## СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)




## БУСАД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

**10.2**
Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа

**11.5**
Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх /хашаа хороо халдваргүйжүүлэлт/

**8.7**
Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх /Үхэр угаалга/

**87.1**
Бог малын туулгалт хийх

**50.0**
Бэлчээрийн менежмент сайжруулах төлөвлөгөө боловсруулах

**5.0**
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх /малын хулгайтай тэмцэх/

**10.0**
Буриад омгийн хонийг үүлдрээр баталгаажуулах хянан магадлагаа хийх үйл ажиллагааны зардал

**20.0**
Буриад омгийн хонинд үзлэг ангилалт, ээмэгжүүлэлт хийх

**12.0**
Буриад омгийн хээлтүүлэгчийн суурь бүрдүүлэх

**20.0**
Малын эрүүл мэндийг хамгаалах

**50.0**
хөрсний дээж шинжилгээ хийх

## МАТАД СУМ

Халхын Сэцэн Хан аймгийн Үйзэн вангийн хошуу нь анх Манжийн Энх-Амгалангийн 5 дугаар онд буюу 1666 онд байгуулагджээ. Тус хошууны анхны засаг ноён Дорждашаас хамгийн сүүлийн ноён Гомбосүрэн хүртэл 9 ноён үе залгамжлан суусан байна. Гомбосүрэн үйзэн засаг хошууны бэйс, засаг төрийн Жун ван, Ардын засгийн үед нэрээ өөрчлөн Нанзаддорж болж, олноо өргөгдсөний (Монгол улсын) 14 дүгээр онд буюу 1924 оны 9 дүгээр сард хошууны ардын төлөөлөгчдийн хурлаар феодалын засгийг өөрчлөн ардын засгийн шинэ хуулийн дагуу Матад хан уулын хошууг анхлан байгуулах үед Үйзэн бэйс тушаалаасаа бууж Матад сум байгуулагдсан юм. Сумын төв Зүүнбулаг нь аймгийн төвөөс 150 км зайтай. БНХАУ-тай зүүн өмнөд хэсгээрээ, өмнөд ба баруун хэсгээрээ Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Сүхбаатар сумдтай, бусад талаараа Булган, Баянтүмэн, Халхгол сумтай хиллэдэг. Зүүн, баруун Матад, Мэнэн, Бадам-Ишийн өргөн уудам тал, Хөх дэрсийн говь, Баруун давс, Тосон Их бага шаварт зэрэг нуур цөөрөмтэй. Газрын тос, уран, нүүрс, жонш, шохой, энгийн зос зэрэг ашигт малтмалтай.

**22.831 км2 газар нутагтай.**




**СУМЫН ТӨСӨВ (сая төгрөг)**



## НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (сая.төг)

| Нийт | Улсын төсөв | Аймгийн төсөв | Сумын төсөв | Аймгийн ОНХС | Сумын ОНХС | Бусад |
|---|---|---|---|---|---|---|
| 2,230.6 | - | 207.0 | 390.1 | 50.0 | 1,528.5 | 55.0 |

## АЙМГИЙН ТӨСӨВ

- **9.0** "Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор инженерийн хийцтэй худаг гаргах, сэргээн засварлах"
- **198.0** Хүүхдийн шинэ цэцэрлэг барих барилгын материал (Матад, Мэнэн баг)

## АЙМГИЙН ОНХС

- **50.0** Соёлын төвд "Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих" танхимд тоног төхөөрөмж

## СУМЫН ТӨСӨВ

- **20.0** Сумын цагдаагийн кабоны барилгын их засвар
- **20.0** Цэцэрлэгт хүрээлэнгийн засвар / ЗДТГ-ын баруун талын талбайд /
- **5.0** Эрдэнэбадрах багийн дээврийн засвар
- **40.0** Засаг даргын Тамгын Газрын гадна дотно засвар
- **4.0** Түмэн хаан багийн нам даралтын тогоо суурилуулах
- **5.0** Ундны усны ашиглалтын зардал 4 худаг
- **4.0** Засаг даргын Тамгын Газрын хяналтын камер
- **18.0** Сумын төвийн камержуулалт
- **8.0** Хүндэтгэлийн асар худалдан авах 2 ширхэг
- **20.0** Иргэний танхимын тоног төхөөрөмж
- **5.1** Цэцэрлэгийн хүүхдийн тоглоомын талбайн тохижилт
- **7.9** ЕБСургуулийн коридорын тохижилт
- **12.2** Нярайн хүүхдийн яаралтай тусламжийн тоног төхөөрөмж
- **10.5** Залуус талбайн тохижилт
- **9.0** Соёлын төвийн гадна талын гэрэлтүүлэг

## СУМЫН ТӨСӨВ

**26.5**
Тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авах ЗДТГ

**7.0**
Эмэгтэйчүүдийн хөгжил хөтөлбөр

**3.0**
Залуучуудын хөгжил хөтөлбөр

**5.0**
Эрдэм шинжилгээний хурал

**5.0**
Үндэсний бөх, сурын спортыг хөгжүүлэх хөтөлбөр

**5.0**
Нохой, муурын устгал

**0.5**
Хамтарсан багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

**3.0**
Багшийн хөгжлийг дэмжих "Эрдэм" хөтөлбөр

**1.0**
"Монгол бичгээ" сурья төсөл

**6.0**
Цагаан сар /ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, үйл ажиллагааны зардал

**3.0**
Ахмадын ачлал хөтөлбөр

**5.0**
Уралдаан, тэмцээн зохион байгуулах, бүсийн чанартай уралдаан тэмцээнд дэмжлэг үзүүлэх

**38.0**
ОНӨ-үйлдвэрийн газрын үйл ажиллагааны зардал

**1.0**
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал хөтөлбөр

**26.9**
Сумын 100 жилийн ойн арга хэмжээг угтаж зохион байгуулах үйл ажиллагааны зардал

**1.0**
Хүмүүнлэгийн дэд хөтөлбөр

**15.0**
Сумын баяр наадмын зардал

**5.0**
Улс , аймаг, сумын сайн малчдад хүндэтгэл үзүүлэх

**3.5**
Матад хан уулын их тахилга

**13.0**
Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламж нэмэгдүүлэхэд суулгац худалдан авах, арчилгаа тордолгоо хийх

**6.0**
Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөр

**12.0**
Нутгийн ирээдүй төсөл хөтөлбөр

**5.0**
Мал тооллогын зардал

**5.0**
Батлан хамгаалахын зардал

## СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)

| Нийт | ОНХС | Малын тоо толгойн албан татвар | Урд оны үлдэгдэл | Уул уурхайн хандив, тусламж | Бусад |
|---|---|---|---|---|---|
| 1,583.5 | 1,245.4 | 201.0 | 82.1 | - | 55.0 |

## СУМЫН ОНХС

**49.0**
Иргэдийн хөгжлийн төв

**33.1**
Усны зөөврийн машин

**9.0**
Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор инженерийн хийцтэй худаг гаргах, сэргээн засварлах

**85.0**
Дотуур байрны их засвар ЕБС

**42.6**
Цахилгаан дамжуулах агаарын 15/0.4 кв-ын 250 ква дэд станц барих

**19.7**
Гудамжны гэрэлтүүлгийн засвар, Нуур хороолол

**19.9**
Гудамжны гэрэлтүүлгийн засвар Өнөр хороолол

**15.0**
Багийн төвийн тохижилт/Баянхангай, Буян-Өндөр, Түмэнхаан/

**15.0**
Хүүхдийн тоглоомын талбай Мэнэн

**18.8**
Соёлын төвийн үндэсний хөгжим

**15.9**
Цэцэрлэгийн анги танхимын тохижилт

**19.3**
Сурын талбайн хашаа

**18.3**
Орон нутгийн түүх, өв соёл тоног төхөөрөмж соёлийн төв

**13.9**
Тоног төхөөрөмж ЕБСургууль

**53.0**
Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /4D эхо/

**495.0**
Сумын төвийн төвлөрсөн халаалт

**154.4**
Сумын төвийн төвлөрсөн халаалтын инженерийн шугам сүлжээний зураг төсөв

**154.6**
Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх

**60.0**
2024 оны хөрөнгө оруулалтын зураг төсвийн зардал

**5.0**
Сумын баяр наадам

## СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)




## СУМЫН ОНХС

**18.0**
Тарвага нутагшуулах

**13.0**
Малын үүлдэр угсаа сайжруулах /Жаргалант, Эрдэнэбадрах баг /

**45.0**
Инженерийн хийцтэй гүн өрмийн худгийн цооног шинээр гаргах

**18.0**
Бог мал угаах ванн /Буян-Өндөр баг, Жаргалант баг/

**25.0**
Бог мал угаах ванн /Түмэнхаан баг/

**40.0**
Худаг /Жаргалант баг, Баянхангай баг /

**20.0**
Гүн өрмийн худаг ухах тоног төхөөрөмж /Буян-Өндөр баг/

**20.0**
Малын тарилга туулгалт хийлгэх /Эрдэнэбадрах баг

**10.0**
Гар худаг шинээр сэргээн засварлах, тоног төхөөрөмж

**5.0**
Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа

**23.0**
Гамшгийн зардал /Жаргалант, Түмэнхаан баг, Эрдэнэбадрах, Буян-Өндөр баг, Жаргалант баг/

**15.0**
Малын чанарыг сайжруулах /Буян-Өндөр баг/

**25.0**
Малын чанарыг сайжруулах /Баянхангай баг/

## БУСАД ЭХ ҮҮСВЭР

**3.0**
Үндсэн үйл ажиллагааны зардал

## СЭРГЭЛЭН СУМ

1931 онд Очирбаярмөнх, Зэндмэн сумдын хэсэг хүмүүсийн санаачилгаар Дунгийн Уртын Ширхэн хашаат гэдэг газар анх байгуулагдсан Хөгнө сум (дарга нь Ч.Аюурзана), 1946 онд Хунт сумын нутагт байгуулагдсан Хэрлэнбаяр сум (дарга нь А.Амгалан) хоёрыг татан буулгаж нэгтгэн АИХ-ын тэргүүлэгчдийн 1961 оны 1-р сарын 1-ний өдрийн зарлигаар Сэргэлэн сумыг байгуулжээ. Ийнхүү халх, үзэмчин, дөрвөд ястнаас бүрдсэн Сэргэлэн сум, Сэргэлэн хараат уулын энгэрт, Галын голын хойт дэнжид зэлүүд газар төвлөрч, хоёр сумын нэгдлүүдийг нэгтгэн "Дөчин жил" хэмээн нэрлэжээ. Сумын төв Сэргэлэн суурин аймгийн төвөөс 70 км, улсын нийслэл Улаанбаатараас 668 км зайнд байна.

**4.169 км2 газар нутагтай.**




**СУМЫН ТӨСӨВ (сая төгрөг)**



## НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (сая.төг)

| Нийт | Улсын төсөв | Аймгийн төсөв | Сумын төсөв | Аймгийн ОНХС | Сумын ОНХС | Бусад |
|---|---|---|---|---|---|---|
| 1,444.1 | 301.3 | 123.7 | 77.0 | 63.9 | 642.3 | 235.9 |

## УЛСЫН ТӨСӨВ

**301.3**
Цэцэрлэгийн барилга, 150 ор

## АЙМГИЙН ТӨСӨВ

**20.6**
Сумдын Цагдаагийн хэсгийн барилгын засвар

**63.1**
Үүрэн холбооны сүлжээний барилга

**40.0**
Цахилгаан дамжуулах агаарын шугам

## АЙМГИЙН ОНХС

**4.9**
Орон нутаг судлах танхимын өргөтгөл

**59.0**
Сумын эрүүл мэндийн төвийн бохир зайлуулах байгууламж

## СУМЫН ТӨСӨВ

**3.0**
Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах, төрийн албанд мэдлэг чадвартай хүний нөөцийг бэлтгэх сургалтын дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг

**1.0**
Тэргүүний байгууллага шалгаруулах болзолт уралдааны зардал

**0.3**
Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар сэтгэл ханамжийн судалгааг иргэдээс авах

**2.0**
Баяр ёслолын үеэр олгох Сумын нэрэмжит шагналын зардал

**1.0**
Цэрэг татлага, бэлтгэл сургуулалт зохион байгуулах

**4.0**
Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сумын цагаагийн хэсэгт шатахууны зардал

**0.5**
Татварын хууль тогтоомжийг сурталчлах зардал

**1.0**
Газар тариалан, бэлчээр, хадлан тэжээлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн хяналтын зардал

**2.0**
Гамшгаас хамгаалах сургалт малчдын бүлгүүдэд зохион байгуулах

**0.5**
Цаг үеийн шинж чанартай сэрэмжлүүлэг мэдээг үүрэн холбооны “mass message” үйлчилгээгээр орон нутгийн иргэдэд хүргэх

## СУМЫН ТӨСӨВ

**2.0**
"Нэг голын хүүхдүүд" төслийн үйл ажиллагаанд дэмжлэг

**2.0**
Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд мод усалгааны зардал

**2.5**
“Ахмадын ачлал хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг

**1.0**
“Эмэгтэйчүүдийн хөгжил" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг

**1.0**
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдэд дэмжлэг

**3.0**
“Малчдын зөвлөгөөн” зохион байгуулах, оролцоход дэмжлэг

**0.5**
“Эх үрсийн элбэрэл” үйл ажиллагаанд дэмжлэг

**0.5**
“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд дэмжлэг

**0.5**
“Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах” зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг

**3.0**
“Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд дэмжлэг

**2.0**
Эрүүл мэндийн салбарын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг

**1.0**
Сумын 80 ба түүнээс дээш настай ахмадуудад хүндэтгэл үзүүлэх

**1.0**
Хамтарсан багийн үйл ажиллагаанд дэмжлэг

**2.5**
“Сэргэлэн сум” нэвтэрхий толь судалгааны ажилд дэмжлэг

**3.0**
Сар шинэ угтах үйл ажиллагаа зохион байгуулах

**2.0**
Багшийн хөгжлийг дэмжих "Эрдэм" хөтөлбөрийн хүрээнд дэмжлэг

**2.0**
Дорнод аймгийн хүүхдийн хөгжил, хүмүүжлийг дэмжих "Хүн болох багаасаа" хөтөлбөрийн дэмжлэг

**1.0**
Соёлын биет бус өв тээгчдийг сурталчлан таниулах

**3.0**
Сумын аварга шалгаруулах спортын тэмцээн уралдааны зардал

**2.0**
Үндэсний спортыг хөгжүүлэхэд дэмжлэг

**0.5**
"Дорнод марафон" нийтийн гүйлт зохион байгуулахад дэмжлэг

**3.0**
Хүүхдийн дугуйлан секцүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг

**2.0**
Соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх “Нүүдэлчин Монгол” наадам, “Соёл урлагийн “Талын Монгол” наадмуудад оролцох зардал

**2.5**
Мал тооллогын зардал

**0.7**
Фотомониторинг хийх

**1.5**
Орон нутгийн “Сор” /брэнд/ бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор

**3.0**
Гамшиг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн

**3.0**
Гамшгаас хамгаалах, ой хээрийн түймрийн үед ашиглах дрон болон

**10.0**
Хүүхдийн цэцэрлэгийн анги бүлгүүдийн зөөлөн эдлэлийг шинэчлэх

## СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)




## СУМЫН ОНХС

- **6.1** Халуун усны газрыг бохирын цооногт холбох, тохижилт хийх
- **40.9** Гудамжны гэрэлтүүлэг
- **15.0** Хот тосгон бусад суурин газрын хянан баталгаа хийлгэх
- **35.3** Цахилгаан дамжуулах агаарын шугам тавих
- **40.0** Цэвэршүүлэх төхөөрөмж бүхий гүн өрмийн худаг
- **20.0** Орон нутаг судлах танхим тохижуулах
- **60.0** Хог хаягдал зөөвөрлөх автомашин худалдан авах
- **25.0** Цэцэрлэгт биеийн тамирын талбай байгуулах
- **5.0** Соёлын төвийн номын санд фонд баяжуулах
- **16.6** ЕБС-ын гал тогооны байршил өөрчлөх
- **50.0** Багш бүрийг компьютержүүлэх
- **20.0** Нийтийн эзэмшлийн гудамж талбайн засвар
- **5.0** Баяр наадмын зардал
- **20.0** Мод тарих
- **1.8** Сумаас орж гарах хаягийн тэмдэг
- **6.0** Агро парк хашаажуулах
- **7.6** Эрүүл мэндийн төвийн цахилгаан монтаж

## СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)




## БУСАД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ


**37.4**
Будүүний булагт хөв цөөрөм байгуулах (Сэргэлэн сум)


**18.7**
Булгийн эх хашиж хамгаалах


**7.5**
Хортон мэрэгчтэй тэмцэх


**47.0**
Булгийн эх хашаалах


**75.0**
Гүн өрмийн худаг


**12.0**
Хуц ухны сууръ барих


**60.0**
Малчдын суурьуудад халдваргүйтгэл хийх /машин тоног төхөөрөмж/


**20.0**
Галын гол дагуу бэлчээр хашаажуулах


**16.2**
Малчдын суурьуудад ариутгал халдваргүйтгэл хийх зардал


**12.0**
Малчдад зориулсан сургалт сурталчилгаа хийж, малын үүлдэр угсааг сайжруулах


**0.9**
Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, орчныг хамгаалах, цэвэрлэх чиглэлээр:


**16.8**
Газар тариалангийн чиглэлээр сумын фондны өвс , тэжээлийн нөөц бүрдүүлэх зардалд


**1.8**
Бараа үйлчилгээний бусад зардал


**216.4**
Төсөл болон дамжуулан зээл олголт, эргэн төлөлт


**0.1**
Бараа үйлчилгээний бусад зардал



## ХАЛХГОЛ СУМ

Одоогийн Халхгол сум нь 1689 онд Сөнөдийн нутаг Ар элстэйд болсон Халхын ноёдын чуулганаар Сэцэн хан аймгийн зүүн гарын дунд хошуу болон Илдэн Вангийн хошуу анх байгуулагдсанаар үүсчээ. Энэ хошууг Н.Пунцаг, П.Чойжав, Ч.Дэмчиг, Д.Цэвээндорж, Ц.Санзайдорж, С.Бат-Очир, Б.Тогтохтөр, Т.Маньбазар, М.Доржпалам нар 1689-1922 он хүртэл угсаа залгамжлан захирч байсан ба 1922-1924 онуудад Д.Жамъянчойжилсүрэн түр захирч байгаад 1924 онд уг хошууг Хан хэнтий уулын аймгийн Халхголын хошуу болгон өөрчилж Буйр нуур, Эрдэнэ мандал, Түмэн-Өлзийт, Халхгол, Цагаан уул, Хунт, Ташгай зэрэг 6 сумтайгаар байгуулжээ. Хошууны өмнөд хэсэгт байсан Хан Чандмань уулын хошуу, Халхголын зүүн өмнө байсан буриад хошууг 1929 онд татан буулгаж Баян-Өлзийт, Сүмбэр могойт, Халх Нөмрөг сумдыг Буйр сумaнд нийлүүлэн нийт 7 сумтай болгожээ. 1931 онд Дорнод аймаг байгуулагдахад Халхголын хошууг татан буулгаж Буйр нуур, Хунт гэсэн хоёр сум болгосон ба 1954 онд хоёр сумыг нэгтгэн Халхгол сум болгожээ. Одоогийн Халхгол сум нь 1994 онд Халхгол, Сүмбэр сум нэгдсэнээр Илдэн Вангийн хошууны 325 жилийн түүхийг өгүүлнэ. Халхгол сум нь баруун талаараа Матад сум, зүүн болон хойд талаараа БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр, Хянган аймгуудтай хиллэдэг. Сумын төв нь аймгийн төвөөс 356 км, нийслэл Улаанбаатар хотоос 1000 гаруй км. Монголын ардын арми, Оросын улаан армитай хамтран Квантуны армийг бут нэргэсэн 1939 оны байлдаанаас эхлээд энэ сум үзэж туулсан түүх арвинтай. Буйр нуур энэ багийн нутаг дэвсгэрт харъяалагдах бөгөөд Хятадтай хиллэдэг цорын ганц усан хил гэдгээрээ онцлог юм.

**28.093 км2 газар нутагтай.**




**СУМЫН ТӨСӨВ (сая төгрөг)**



## НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (сая.төг)




## АЙМГИЙН ТӨСӨВ

**339.0**
Хамар давааны авто зам, замын байгууламжийн засвар

**24.0**
"Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор инженерийн хийцтэй худаг гаргах, сэргээн засварлах"

## СУМЫН ТӨСӨВ

**200.0**
То вангийн өв соёлын өргөө

**5.0**
Гамшгийн хамгаалах бэлэн байдлыг хангахад зориулж багаж тоног төхөөрөмж.

**3.0**
ИТХ

**5.0**
Статистикийн программ хангамжийг сайжруулах

**7.0**
Сургууль

**5.0**
Ялалт музей

**6.0**
Хүүхдийн цэцэрлэг

**2.0**
Суурь өвчлөлттэй болон зорилтот бүлгийн хүүхдүүдийг зуны сувилалд хамруулах ажлыг үргэлжлүүлнэ.

**2.0**
Ахмадуудын өдрийн сувиллыг үргэлжлүүлэн ажиллуулж, хамрагдагсдын тоог нэмэгдүүлнэ.

**3.0**
"Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр" -ийг хэрэгжүүлнэ. /2017-2026/

**8.0**
Буйр нуурын загасны нөөц тогтоох

**2.0**
Багшийн хөгжлийг дэмжих аймгийн "Эрдэм" хөтөлбөр (2021-2024 он)-ийг үргэлжлүүлнэ.

**1.0**
"ЭЕШ-2021" эрчимжүүлсэн сургалтын үйл ажиллагааны зардал болон элсэлтийн ерөнхий шалгалтанд амжилт үзүүлсэн, ахиц гаргасан багш, сурагчдыг урамшуулна.

**3.0**
Сумын төвийн сургууль цэцэрлэг багш ажиллагсад, болон хүүхдүүдэд хүйтний улирлад нийтийн тээврийн унаагаар үйлчилнэ.

**14.0**
Баяннуур орчим хог цэвэрлэгээ

## СУМЫН ТӨСӨВ

**14.0**
Буйр нуурын хог цэвэрлэгээ

**1.0**
"Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дэд хөтөлбөр" үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

**1.0**
Нэг өрх-Нэг ажлын байр хөтөлбөр хэрэгжүүлнэ.

**2.0**
"Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгаалал" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

**3.0**
Ахмадын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

**3.0**
Эмэгтэйчүүдийн хөгжил, оролцоо, манлайллыг хөгжүүлэх зорилгоор “Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.

**7.0**
Аймгийн "Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

**1.0**
“Бэлчээр, хадлан тэжээлийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг хангаж ажиллана.

**1.0**
Төмс хүнсний ногоо тариалалтыг дэмжих, хөнгөлөлттэй үрээр хангах ажлыг зохион байгуулна.

**9.0**
Аймаг сумын тахилгат уул, овоо, тахих үйл ажиллагаар зохион байгуулж өв уламжлал суртчилсан аялалжуулдын тоог нэмэгдүүлнэ.

**3.0**
"Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-2"-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

**9.0**
"Төрийн албан хаагчийн сургалт, хөгжил, нийгмийн баталгааг дэмжих" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

**3.0**
Архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчимжүүлж, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

**1.0**
Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.

**3.0**
Сумын хил хамгаалах туслах хүчний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

**3.0**
Цагдаагийн тасгийн үйл ажиллагаанд шатах тослох материалын дэмжлэг үзүүлнэ.

**2.0**
Малын хулгайтай тэмцэх ажлыг эрчимжүүлнэ.

**3.1**
Сумын хэмжээнд хүүхэд залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх, батлан хамгаалах салбарын талаарх хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах

**1.5**
Хугацаат цэрэг татлагыг зохион байгуулж, цэргийн жинхэнэ алба хаасан болон цэргийн жинхэнэ албанд татагдаж байгаа залуучуудыг үгтан авах, үдэн гаргах ажлыг зохион байгуулна.

**3.0**
Цагаан сар /Сумын ахмад болон өндөр настанд хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулна/

**2.5**
Сумын жилийн эцсийн мал тооллого зохион байгуулах.

**19.0**
Хот суурин газрын төлөв байдлын чанарын хянан баталгаа

**8.4**
Хог цэвэрлэгээ

**1.0**
Хүүхдийн хөгжил хамгаалал хүүхдийн эрүүл зөв хооллолт дэмжих

## СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)

| Нийт | ОНХС | Малын тоо толгойн албан татвар | Урд оны үлдэгдэл | Уул уурхайн хандив, тусламж | Бусад |
|---|---|---|---|---|---|
| 2,271.1 | 1,603.2 | 100.0 | 50.0 | 510.0 | 7.9 |

## СУМЫН ОНХС

**236.5**
Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн засвар / уурын зуух/

**651.2**
"Тавтай морилно уу" авто замын ус гаргуур, үерийн ус зайлуулах сувгийн засвар шинэчлэлт

**40.0**
Хогны машин

**40.0**
Мал тарилгын хашаа, угааврын ванн /Ташгай баг/

**40.0**
Мал тарилгын хашаа, угааврын ванн /Ялалт баг/

**30.0**
Хүүхэд, залуусын талбай /Ялалт баг/

**40.0**
Буйр нуурын өргөтгөл цахилгаан

**10.0**
Буйр нуурын соёлын төвийн барилгын засвар үйлчилгээ

**600.0**
Зэвсэгт хүчний 329-р ангиас сумын төв хүртэлх зам засварын ажил

**30.0**
Цахилгаан дамжуулах агаарын шугам засварлах сумын төв

**35.0**
Худаг /Ялалт баг /

**125.0**
Универсал трактор

**14.0**
Худаг сэргээн засварлах /Ялалт баг/ 2 худаг

**14.0**
Худаг сэргээн засварлах /Ташгай баг/ 2 худаг

**24.0**
АДАПТ худаг

**5.0**
Улсын баяр наадмын зардал

**60.6**
Мал амьтан халдварт, шимэгч өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирол арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх

**120.0**
Ногоон байгууламж, сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайн тохижилт

**20.0**
Зөвлөх үйлчилгээ /БО хамгаалах хууль/

**4.0**
Малчдын зөвлөгөөн

## СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)




## СУМЫН ОНХС



**100.0**
Ус хангамж, бохир ус, цэвэрлэх байгууламж бий болгох, усны аж ахуйн хөнгөлөлт үйлчилгээ

## БУСАД ЭХ ҮҮСВЭР



**40.0**
Буйр нуурын эрэг орчмын жуулчны баазууд, отоглох цэгүүдийн хог хаягдал, хөрс,орчны бохирдлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх чиглэлээр хэсэгчилсэн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгэх



**112.5**
Буйр нуурын эрэгт цөлжилтөөс хамгаалах зорилгоор ойн зурвас, хашаа



**120.0**
"Буйр нуурын эрэг орчмын цөлжилт, элсний нүүдлээс хамгаалах" менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардал



**20.0**
Идэвхтэн байгаль хамгаалагчдыг ажиллуулж, урамшуулах, сургалт зохион байгуулах (Халхгол сум)



**7.9**
Байгаль орчин, газрын хөрснөхөн сэргээх зардал

## ХӨЛӨНБУЙР СУМ

Өвөр Монголын Өөртөө Засах орны Хөлөнбуйр аймгаас 89.1 мянган толгой малтай 256 өрхийн 997 хүн ам 1945 онд нүүдэллэн ирж, Чойбалсан хотын Хөлөнбуйр сум нэртэйгээр байгуулагдсан. Мөн 1956 онд тус аймгийн Түмэндэлгэр сумаас 30 гаруй мянган толгой мал бүхий 70 өрхийн 220 хүн ам нэмэгдэн ирж сум өргөжсөнөөр засаг захиргааны 3 нэгжтэй болсон.

Тухайн үеийн нам засгийн бодлого шийдвэрээр тус сумын иргэд нэгдэлжих хөдөлгөөнд хамрагдаж "Шинэ-зам", "Баянцагаан", "Оч", "Баян-Өлзийт" зэрэг нэртэйгээр зохион байгуулагдаж байв. 1992 онд нэгдэл үйл ажиллагаагаа зогсоож, 22.9 сая төгрөгийн хөрөнгийг 836 гишүүддээ хувьчлан өгч, сумаараа хувийн аж ахуйтан болцгоож байв.

Тус сумын засаг захиргааны төв байгууллага нь 1945 онд Ардын Депутатын Хурлын Гүйцэтгэх Захиргаа, 1955 онд "Шинэ-зам" нэгдэл, 1992 оны 10 дугаар сарын 1-нээс Засаг даргын Тамгын газар нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

**3.773 км2 газар нутагтай.**




**СУМЫН ТӨСӨВ (сая төгрөг)**



## НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (сая.төг)




## УЛСЫН ТӨСӨВ АЙМГИЙН ОНХС АЙМГИЙН ТӨСӨВ

**384.9**
Дотуур байрны барилга, 100 ор

**10.0**
Ерөнхий боловсролын сургууль, Соёлын төвийн тохижилт

**45.3**
Соёлын төвийн барилгын халаалтын шугамын засвар

**12.5**
Мал эмнэлгийн хорио цээр, ариутгал халдваргүйтгэлийн хяналтын цэг байгуулах ажлын зураг төсвийн зардал

**45.1**
Хүүхдийн цэцэрлэгийн хуучин барилгын засвар

## СУМЫН ТӨСӨВ

**1.8**
Чадварлаг багш хөтөлбөр

**4.0**
Дотуур байрны халаалтын тогоо

**0.5**
Монгол бичгээ сурцгаая

**1.5**
Эрүүл мэндийн хөтөлбөр

**0.5**
Хамтарсан баг хөтөлбөр

**1.5**
Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр

**1.0**
Үндэсний бөхийн спортыг дэмжих хөтөлбөр

**2.0**
Ахмадын ачлал хөтөлбөр

**0.5**
Нэг-өрх нэг ажлын байр хөтөлбөр

**0.5**
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгаалах хөтөлбөр

**2.0**
Боловсон хүчний бодлого хөтөлбөр

**0.5**
Жендерийн эрх тэгш байдлын хангах дэд хөтөлбөр

**0.5**
Хөдөлмөр аюулгүй байдлыг бэлтгэх хөтөлбөр

**1.8**
Мэндийн ерөөлтэй Дорнод хөтөлбөр

**3.0**
Цэцэрлэгийн БИО 00-ын засвар

## СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)




## СУМЫН ОНХС

- **20.0** Цэвэр орчин төсөл
- **15.0** Гамшгаас хамгаалах зардал
- **5.0** Үндэсний баяр наадмын зардал
- **20.0** Ногоон байгууламж хашаа, засвар үйлчилгээ
- **15.0** Гүүр манаачийн байр
- **35.0** Хүүхэд залуучуудын талбайн засвар, фитнес тоног төхөөрөмж
- **40.0** Хог хаягдал хашаажуулалт
- **33.0** ЕБС-ын англи хэлний кабинетийн тоног төхөөрөмж
- **15.0** Номын сангийн тохижилт /ширээ сандал/
- **49.7** ЭМТ-ийн дээврийн засвар
- **20.0** Багийн төвийн тохижилт
- **8.6** Камержуулалт /СӨБ/
- **13.9** Ажлын байрыг нэмэгдүүлэх /Авто зам, био байгууламж
- **40.0** Бэлчээрийн гүн өрмийн худаг гаргах цэг тодорхойлуулах, засвар хийлгэх-3 худаг, шинээр цооног гаргах 2 ш худаг
- **20.0** Мал угаалгын ванн 2 ш засвар, цооног 1 ш гаргах
- **45.0** Халдваргүйжүүлэх ариутгалын машин
- **6.0** Малчдын зөвлөгөөн

## ЦАГААН-ОВОО СУМ

1929 онд Засгийн газрын шийдвэрээр Халх Нөмрөгийн хошуу татан буугдаж Халхголын хошууны хоёр сум болж нэгдсэний дараа энэ хоёр сумынхан 1930 онд нүүдэллэн одоогийн Сэргэлэн сумын нутаг Хөгнийн шилийн өвөрт, Бүдүүний булагт төвлөж Яргайт гэдэг шинэ сум байгуулж Улз голын хошуунд харъяалагджээ. Хошуудыг татан буулгасны дараа сумдыг томсгон зохион байгуулах үед Саруул гүн, Эрдэнэ гүний хошуунд харъяалагдаж байсан хэсэг халхчууд, Тариалан сумын харъяанд байсан Шалз таван толгой, Элст бөөн, Үет цагаанаар нутаглаж байсан буриадууд нийлж Эрвээхэй Галуут сум (дарга нь М.Очир, нарийн бичгийн дарга нь Молор-Эрдэнэ) байгуулсан байна. Энэ сум 1932 онд Шар шувуут (Түмэндэлгэр) уулын зүүн суганд байдаг Хүрэн хөндий гэдэг газар төвлөрч 1935 он хүртэл оршиж байгаад сумын ард олны хүсэлтээр задарч нэг хэсэг нь Түмэндэлгэр сумын нэг баг болон шилжиж хуучин Эрдэнэ гүний хошууны нутаг байсан Дөрөө гэдэг газар нутаглах болсон байна. Нөгөө хэсэг нь 1935 оны 5-р сарын 19-ний өдөр Ардын төлөөлөгчдийн хурал хийж бие даасан сум болох асуудлыг хэлэлцэж санал хүсэлтээ аймгийн яаманд явуулжээ. Энэ хүсэлтийг үндэслэн 1935 оны 5-р сарын 27-ны тогтоолоор сум байгуулахыг зөвшөөрчээ. Сумын нутагт XI зууны Киданы үеийн «Хэрлэн Барс» хотын туурь бий.

**6.502 км2 газар нутагтай.**




**СУМЫН ТӨСӨВ (сая төгрөг)**



## НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (сая.төг)




### УЛСЫН ТӨСӨВ

**166.3**
Дотуур байрны барилга, 150 ор

### АЙМГИЙН ТӨСӨВ

**6.0**
"Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор инженерийн хийцтэй худаг гаргах, сэргээн засварлах"

### АЙМГИЙН ОНХС

**191.8**
Ерөнхий боловсролын сургуулийн барилгын засвар

**100.0**
"Мянган зоорь" төслийн хүрээнд шинэ зоорь

### СУМЫН ТӨСӨВ

**64.0**
Цэвэр бохир усны шугам /ЭМТ/

**13.0**
Цэвэр бохир усны шугам /Сургууль, цэцэрлэг/

**56.4**
Тайзны автомат хөшиг, гэрэлтүүлэг

**28.0**
Нийтийн ариун цэврийн байгууламж нэмэгдүүлэх

**18.0**
Баяр наадмын асар майхан

**12.8**
Архивын нягтруулсан шүүгээ

**6.0**
Хүүхэд хөгжлийн өрөө

**10.6**
Цахим тоног төхөөрөмж

**15.8**
Камер шинэчлэлт /Цэцэрлэг/

**13.9**
ЗДТГ-ын ажилчдын тоног төхөөрөмж

**757.0**
ЗДТГ-ын дээвэр төсөвт байгууллагуудын гадна фасад авто зогсоол

**10.0**
Цэвэр усны байгууламжийн хэвийн үйл ажиллагааг хангах

**10.0**
Баяр наадмын зардал

**2.0**
Цагаан-Овоо сумын хөгжлийн чиг хандлага тодорхойлох нээлттэй форум

**3.0**
Цагаан сарын үйл ажиллагаа

## СУМЫН ТӨСӨВ

**1.0**
ХХҮГ сургалт, өдөрлөгийн арга хэмжээ

**10.0**
Залуучуудын бага наадам зохион байгуулах

**2.0**
Татвар төлөгчдийн өдөрлөг

**5.0**
Оюунлаг, авъяаслаг, спортлог Цагаан-Овоочууд дэд хөтөлбөр

**1.0**
Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа

**2.0**
Ахмадын баярын үйл ажиллагаа

**2.0**
Хүүхдэд ээлтэй орон нутаг

**2.0**
Батлан хамгаалахын зардал

**1.0**
Хууль эрхзүйн өдөрлөг төрийн албан хаагчдын зөвлөгөөн

**10.0**
"Төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа хангах" хөтөлбөр

**2.0**
Ахмадын ачлал хөтөлбөр

**4.0**
Зочид төлөөлөгчид гадаад арга хэмжээний зардал

**7.0**
Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд жимсний мод худалдан авах

**1.5**
Өвс тэжээлийн агуулах, саравч камержуулах

**15.0**
Баянгол адгийн гарам

**13.2**
Сургалт зөвлөгөөн хяналт шалгалт

**30.0**
Малын үүлдэр угсаа сайжруулах /хар ямаа/

**5.0**
Малын үүлдэр угсаа сайжруулах /буриад омгийн хонь/

**15.0**
Малын үүлдэр угсаа сайжруулах /шилмэл малын үзэсгэлэн худалдаа/

**15.0**
Малын ашиг шим дээшлүүлэх

**20.0**
Угаарын ванн

**45.0**
Трактор

**6.0**
Инженерийн хийцтэй худаг

**5.8**
Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх

**12.0**
Хээлтүүлэгч малын хашаа

## СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)




## СУМЫН ОНХС

**90.0**
Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц

**54.5**
Бэлчээрийн хянан баталгаа

**20.3**
Багийн хилийн цэсийг шинэчлэн тогтоох

**191.8**
ЕБС-ийн барилгын засвар

**100.0**
Мянган зоорь төслийн хүрээнд шинэ зоорь

**210.4**
Стандарт эмийн сан, лабораторын барилга

**112.6**
Цахилгаан дамжуулах агаарын шугам өргөтгөл

**150.0**
Гүн цэнгэлэг нуурын эко систем хамгаалах, тохижуулах

**20.0**
Нийтийн эзэмшлийн арчилгаа, хог цэвэрлэгээ

**180.0**
Төвлөрсөн хогийн цэгийг ландфилдийн аргаар булшлах тохижуулах

**20.0**
Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод үржүүлэх

**5.0**
Сумын баяр наадмын зардал

**18.9**
Гудамжны гэрэлтүүлэг засвар арчилгаа

## ЧОЙБАЛСАН СУМ

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор 1931 онд хуучин хошуудыг татан буулгаж нэгтгэх, шинэ аймаг, сум, баг байгуулах ажил явагдах үед Очирсүмбэр, Дэлгэрмөнх, Баянталбай сумдыг нийлүүлж нэг сум болгон Давст сум гэж нэрлэжээ. Энэ сум нь 10 гаруй багтай нэлээд том сум болсон байна. 1935 онд Давст сумын төлөөлөгчдийн хурал хуралдаж, хурал дээр олон төлөөлөгчдөөс сумын нэр нь зохимжгүй байна, олонд алдаршсан хуучин гурван сумын ард олонд тааламжтай гурван газрын нэрээс адил тэгш оруулж сумаа нэрлэх нь зүйтэй гэж санал гаргасныг үндэслэн хурлаас сумын нэрийг хуучин Очирсүмбэр сумын нэрээс “Очир”, Баянталбай сумын нэрээс “Баян”, Дэлгэрмөнх сумын нэрээс “Мөнх” гэдэг нэрийг авч “Очирбаянмөнх” сум гэж нэрлэн 15 багтайгаар зохион байгуулжээ. 1944 онд УБХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор Очирбаянмөнх сумын нэрийг өөрчилж БНМАУ-ын хошой баатар, маршил Чойбалсангийн нэрээр нэрлэсэн байна. Сумын төв нь аймгийн төвөөс хойш 55 км зайд оршино. Дорнод Монголын төмөр замын Хэрлэнгол өртөө тус сумын төвд байдаг.

**10.152 км2 газар нутагтай.**




**СУМЫН ТӨСӨВ (сая төгрөг)**



## НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (сая.төг)

| Нийт | Улсын төсөв | Аймгийн төсөв | Сумын төсөв | Аймгийн ОНХС | Сумын ОНХС | Бусад |
|---|---|---|---|---|---|---|
| 1,104.5 | - | 101.0 | 151.8 | 100.7 | 751.0 | |

## АЙМГИЙН ТӨСӨВ

**89.0**
Засаг даргын тамгын газрын барилгын дээврийн засвар

**12.0**
"Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор инженерийн хийцтэй худаг гаргах, сэргээн засварлах"

## АЙМГИЙН ОНХС

**60.0**
Нийтийн эзэмшлийн зам, талбайн тохижилт

**40.7**
Цэцэрлэгийн халаалтын тогооны засвар

## СУМЫН ТӨСӨВ

**18.0**
Төсөвт байгууллагын хяналтын камер

**89.0**
ЗДТГ-ын барилгын дээврийн засвар

**20.0**
ЗДТГ-ын пургон автомашины иж бүрдэл засвар

**5.0**
Ахмадын ачлал хөтөлбөр

**4.5**
Золбин нохой устгах

**0.5**
Цэрэг татлага

**2.5**
Мал, тэжээвэр амьтны улсын үзлэг тооллого зохион байгуулах

**5.0**
Төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгаар хангах хөтөлбөр

**3.0**
Улаан загалмайн анхан шатны хороодын зөвлөгөөн

**0.5**
Худалдан авах ажиллагааны АЗ сургалт

**2.0**
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал

**1.8**
Ундны усны цэвэршүүлэгч төхөөрөмж филтер

## СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)




## СУМЫН ОНХС

| | | | | |
|---|---|---|---|---|
| **100.0** Зураг төсөв /Нэгдсэн халаалт/ | **20.0** Хүүхэд болон ахмадын сувилалын байрны торх | **50.0** Цэцэрлэгийн гадна талбайн тоглоом | **40.0** Ундны усны цэвэршүүлэгч төхөөрөмж суурилуулах | **80.0** Гудамжны гэрэлтүүлэг |
| **220.0** Гудамж тохижилт | **40.0** Сургуулийн хичээлийн хэрэглэгдэхүүн | **5.0** Улсын баяр наадам | **20.0** Тэрбум мод хөтөлбөр | **30.0** Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр |

## БУСАД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

| | | | | |
|---|---|---|---|---|
| **12.0** Бэлчээрийн усан хангамж нэмэгдүүлэх худаг гаргах | **10.0** Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тэмцэх | **110.0** Эцэг малын үүлдэр, угсаа сайжруулах | **6.0** Малын хулгайн гэмж хэрэгтэй тэмцэх | **8.0** Гамшигаас хамгаалах тоног төхөөрөмж |

## ЧУЛУУНХОРООТ СУМ

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1956 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 197 дугаар тогтоолд: "...Чойбалсан аймгийн Дашбалбар сумын нутагт мал үржүүлэх ажил голлон эрхэлсэн Чулуунхороот гэдэг нэртэй сангийн аж ахуйг 1956 онд байгуулсугай" гэж зааснаар Дашбалбар сумын 4-р багийн Чулуунхоротын уурхайг татан буугдахад байшин барилгыг нь түшиглүүлэн СAA-г байгуулсан байна. Чулуунхоротын СAA хэмээн байгуулагдсан бөгөөд 1959 онд засаг захиргааны зохион байгуулалтаар сумыг шинээр байгуулж Чулуунхороот гэж нэрлэн, СAA-г Эрээнцав гэж нэрлэхээр тогтжээ. Шинээр байгуулагдсан сумын даргаар Б.Аюур, нарийн бичгийн даргаар Б.Цэрэнпүрэв нар сонгогджээ. СAA-н үйлдвэрлэлийн хүрээг өргөжүүлж үр тариа, мал аж ахуйг хослуулан эрхлүүлэх зорилгоор Сайд нарын Зөвлөлийн 1961 оны 2-р сарын 15-ны өдрийн 61-р тогтоолоор сумын төвийг Эрээнцавын нутагт нүүлгэжээ. 1970-аад онд ЗХУ-ын хүч хөрөнгөөр сум, СAA-н төвийг орчин үеийн барилгаар тохижуулсан юм. Сумын төв Эрээнцав нь Оросын Холбооны Улсын хилд ойрхон оршино.

**6.539 км2 газар нутагтай**




**СУМЫН ТӨСӨВ (сая төгрөг)**



## НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (сая.төг)




### УЛСЫН ТӨСӨВ

**872.3**
Эрээнцавын шалган нэвтрүүлэх заставын өргөтгөл, хилийн отряд шинээр байгуулах

**440.7**
Улз голын төмөр бетон гүүр /Дорнод, Чулуунхороот сум/

### СУМЫН ТӨСӨВ

**22.0**
Төрийн байгууллага, олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах, сурталчилах төрийн албан хаагчдын ажиллах, суралцах нөхцөл боломжийг дэмжих дэд хөтөлбөрийн хэрэгжилт

**7.0**
Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл боломжийг сайжруулахад тоног төхөөрөмж худалдан авах

### АЙМГИЙН ОНХС

**42.1**
Ерөнхий боловсролын сургуулийн барилгын цонх шинэчлэх

### АЙМГИЙН ТӨСӨВ

**327.0**
Сумдад нэн хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдад зориулсан орон сууцны барилга

**6.6**
"Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор инженерийн хийцтэй худаг гаргах, сэргээн засварлах"

**27.0**
Онцгой байдлын үед хэрэглэх хадлан, өвс тэжээлийн агуулах 2 суманд барих

**20.0**
Соёлын төвийн ариун цэврийн байгууламж

## СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)

| Нийт | ОНХС | Малын тоо толгойн албан татвар | Урд оны үлдэгдэл | Уул уурхайн хандив, тусламж | Бусад |
|---|---|---|---|---|---|
| 747.3 | 492.3 | 40.0 | 215.0 | - | |

## СУМЫН ОНХС

**200.0**
Суманд нэн хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж байгаа төрийн албан хаагчдад зориулсан орон нутгийн өмчийн орон сууцны барилгад дэмжлэг үзүүлэх

**15.0**
Нэг цэгийн үйлчилгээний өмнөх авто зогсоол

**5.0**
Улсын их баяр наадам

**16.0**
Сургуулийн гадна орчныг камержуулах

**20.0**
Соёлын төвийн дотор 00
д дэмжлэг

**20.0**
Гадна гэрэлтүүлэгийн засвар

**20.0**
Хог хөтөлбөрийн үргэлжлэл

**55.0**
Алсын дуудлага, гамшиг ослын үед түргэн шуурхай тусламж үзүүлэх авто машин

**35.0**
Ахмад настны чөлөөт цагаа өнгөрүүлэх төвийг өргөтгөхөд дэмжлэг

**20.0**
Сургуулийн хүүхдүүдэд сурах орчныг бүрдүүлэхэд Монгол хэлний кабинетий тохижуулж засварлахад дэмжлэг үзүүлэх

**10.0**
Төсөвт байгууллагын сангийн үйлчилгээ

**20.0**
Сургуулийн амралт чөлөөт цагаар хүүхдүүдэд зөв хүмүүжил, хичээл практикийг амьдралд ойртуулах зааж сургах хөдөлмөр зусланг байгуулахад дэмжлэг үзүүлэх

**10.0**
Сургуулийн амралт чөлөөт цагаар хүүхдүүдэд зөв хүмүүжил, хичээл практикийг амьдралд ойртуулах зааж сургах хөдөлмөр зусланг байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж материал худалдан авах

**20.0**
Ахмад настангуудад зуны сувилал, уламжлалт эмчилгээнд хамрагдахад байр гэрийн дэмжлэг үзүүлэх

**20.0**
"Хүн болох багаасаа" хөтөлбөрийн хүрээнд "Жишиг анги-2" төсөл

**6.5**
Хилийн боомтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж иргэдийг хилээр нэвтрэх үеийн шуурхай байдлыг хангах пункт барих

**2.0**
Наадмын талбайн урсгал засвар

**8.0**
Сумын 9 гайхамшигийг тодруулж алдаршуулах

**50.0**
Спорт зааланд хүүхэд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих зорилгоор бялдаржуулах тоног төхөөрөмж худалдан авах

**16.5**
Хүн болох багаасаа хөтөлбөрийн хүрээнд хүүхдүүдийн авъяас чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн дэмжлэг үзүүлэ

## СУМЫН ОНХС

**70.0**
Жаргалан хороолол руу дэд бүтэц татах 2023-2024 он

**27.0**
Онцгой байдлын үед ашиглах хадлан, өвс тэжээлийн агуулах барих.

**6.5**
Гамшгаас хамгаалах авто пургоны тоноглол, бэхэлгээ хийх.

**5.6**
орон нутгийн өмчийн нийтийн эзэмшлийн талбайн тохижилтод дэмжлэг үзүүлэх.

**6.0**
Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор инженерийн хийцтэй 2 худаг гаргахад дэмжлэг үзүүлэх.

**5.2**
Гамшгаас хамгаалах үеийн шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах

**18.0**
Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог сайжруулахад, иргэдийг хүлээж авах үйлчилгээний байрны тохижилт

**8.5**
“Малчдын зөвлөгөөн–2023” зохион байгуулах

**6.0**
Мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах зорилгоор аймаг, сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх.

**4.5**
Цагаанчулуут багийн цахилгааны эх үүсвэр

**10.0**
Галуут, Цагаанчулуут багуудын хүний хөгжлийн төвийн халаалт

**7.0**
малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх

**1.5**
Малчид болон мал бүхий иргэдэд сургалт зохион байгуулна.

**2.5**
Гамшгаас хамгаалах үлээгч аппарат

# НЭР, НЭРШЛИЙН ТАЙЛБАР

**ТӨСВИЙН ОРЛОГО:**

Хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого

**ТӨСВИЙН ЗАРЛАГА:**

Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан төсвөөс хуваарилан, зарцуулах хөрөнгө

**ТЭНЦЭЛ:**

Тухайн төсвийн жилийн төсвийн нийт орлого, зарлагын зөрүү

**ОРОН НУТГИЙН ТӨСӨВ:**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-аас баталсан, тухайн шатны төсөвт харьялагдах ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах хөрөнгө

**ТӨСВИЙН АШИГ:**

Төсвийн зарлагаас давсан орлого

**ТӨСВИЙН АЛДАГДАЛ:**

Төсвийн орлогоос давсан зарлага

**ТӨЛӨӨЛӨН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТӨРИЙН ЧИГ ҮҮРЭГ:**

Нэгжийн удирдлагад төрөөс шилжүүлсний дагуу түүний нэрийн өмнөөс хэрэгжүүлэх эдийн засаг, нийгмийн шинжтэй асуудлууд

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:**

Төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн зардлыг хөрөнгө оруулалт гэнэ

**ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САН:**

Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгө

**ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО:**

Тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь, хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэр

**ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ЗАРЛАГА:**

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлагын нийлбэр

**ТӨСВИЙН ТОДОТГОЛ:**

Тухайн жилийн төсвийг баталсан эрх бүхий байгууллагын шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулахыг төсвийн тодотгол гэнэ



# АЙМАГ, СУМЫН ЧИГ ҮҮРЭГ:

| | ЗЗНДНТУТХ-ийн 21-22-р зүйл | Аймаг | Сум |
|---|---|---|---|
| НУТГИЙН УДИРДЛАГА | Аймгийн дунд хугацааны хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт | ✓ | |
| | Сумын хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт | | ✓ |
| | Орон нутгийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналт | ✓ | ✓ |
| | Орон нутгийн төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт | ✓ | ✓ |
| | Хууль тогтоомжид заасан хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох | ✓ | ✓ |
| | ОНХС-гийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт | ✓ | ✓ |
| | Аймгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр | ✓ | |
| | Аймгийн хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжилт, ажиллах нөхцөл | | ✓ |
| ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧИН | Аймгийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөр, хэрэгжилтэд тавих хяналт | ✓ | |
| | Аймгийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөрийн хэрэгжилт | | ✓ |
| | Аймгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн менежмент | ✓ | |
| | Аймгийн аялал жуулчлалын бодлого, менежмент | ✓ | |
| | Аялал жуулчлалын үйл ажиллагааны зохицуулалт | | ✓ |
| ХОТ, НИЙТИЙН АЖ АХУЙ, ДЭД БҮТЭЦ | Орон сууц, нийтийн аж ахуйн удирдлага | | ✓ |
| | Гудамж, талбайн нэр, хаягжилтын нийтлэг зохицуулалт | ✓ | |
| | Суурин газрын гэрэлтүүлэг, арчлалт | | ✓ |
| | Харилцаа, холбоо, цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт, | ✓ | |
| | Сум хоорондын нийтийн тээврийн зохицуулалт | ✓ | |
| | Сумын хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалт | | ✓ |
| | Орон нутгийн зам, гүүр тэмдэг, тэмдэглэгээ, арчлалт, хамгаалалт | | ✓ |
| | Суурин газрын замын хөдөлгөөн, авто зогсоолын зохицуулалт | | ✓ |
| | Нийтийн зэмшлийн зам талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалт | | ✓ |
| | Орон нутгийн цэвэрлэх байгууламжийн арчлалт | | ✓ |
| | Гал түймэр, үерийн хамгаалалтын байгууламж, суваг шуудуу, арчлалт | | ✓ |
| | Аюултай болон үйлдвэрлэлийн хог хаягдлын менежмент | ✓ | |
| | Хог хаягдлын цэгийн байршил, энгийн хог хаягдлын менежмент | | ✓ |
| | Оршуулгын газрын үйл ажиллагааны зохицуулалт | | ✓ |
| ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ | Худалдаа, үйлчилгээний нийтлэг зохицуулалт | ✓ | |
| | Худалдаа, үйлчилгээний зохион байгуулалт, хяналт | | ✓ |
| НИЙГЭМ, СОЁЛЫН САЛБАР | Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, нэгдсэн эмнэлэг, аймгийн музей, театр, номын сан, соёлын ордон, биеийн тамир, спортын цогцолборын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээ | ✓ | |
| | Сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, номын сан, биеийн тамир, спортын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээ | | ✓ |
| | Хөшөө дурсгалын нийтлэг зохицуулалт | ✓ | |
| | Хөшөө дурсгалын байршил, хамгаалалт | | ✓ |

# ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| **ДНБ** | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| **ЕБС** | Ерөнхий боловсролын сургууль |
| **ЗАН** | Заах аргын нэгдэл |
| **ЗДТГ** | Засаг даргын Тамгын газар |
| **ЗЗНДНТУТХ** | Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль |
| **ИТХ** | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал |
| **НДШ** | Нийгмийн даатгалын шимтгэл |
| **ОНӨААТҮГ** | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| **ОНХС** | Орон нутгийн хөгжлийн сан |
| **СӨББ** | Сургуулийн өмнөх боловсролын байгууллага |
| **ТБОНӨХБАҮХАТ** | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай |
| **УИХ** | Улсын Их Хурал |
| **ЭМТ** | Эрүүл мэндийн төв |

## АЙМАГТАЙ ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

| Дорнод аймаг, Хэрлэн сум, 9-р баг, Баянтүмэнгийн гудамж, Засаг даргын тамгын газрын байр | |
|---|---|
| Дорнод аймгийн ЗДТГ-ын байр | Утас: 70582233 |
| Цахим хаяг | info@dornod.gov.mn |
| Facebook хаяг | https:/www.facebook.com/dornod.gov.mn/<br>Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар |

**Сумын Засаг даргын ажлын алба болон сум, өрхийн эрүүл мэндийн төв**

| № | Сумын нэр | Сумын засаг даргын гар утас болон ажлын албаны утас | Сум, ӨЭМТ-ийн утас |
|---|---|---|---|
| 1 | Баяндун | 881012788, 7058-0000 | 8537-0103 |
| 2 | Баян-Уул | 88086741, 9415-0909 | 7058-6307 |
| 3 | Баянтүмэн | 88093779 | 8946-1000 |
| 4 | Булган | 88095662 | 9856-1660 |
| 5 | Гурванзагал | 8810-5184 | 8975-5001 |
| 6 | Дашбалбар | 8811-6079 | 7058-6609 |
| 7 | Матад | 88013991 | 8058-1810 |
| 8 | Халхгол | 8810-1367 | 8058-3103 |
| 9 | Хөлөнбуйр | 8924-0208, 9832-4884 | 8313-0103 |
| 10 | Сэргэлэн | 8857-3758, 9326-9996 | 9158-2303 |
| 11 | Цагаан-Овоо | 9152-2425 | 9658-0016 |
| 12 | Чойбалсан | 8911-6916 | 8958-3803 |
| 13 | Чулуунхороот | 8805-9577, 99049577 | 8899-6059 |
| 14 | Хэрлэн | 9908-3758, 7058-4740 | “Асралт Үйлс” ӨЭМТ 7058-3391<br>“Мянган жаргалан” ӨЭМТ 9820-3439<br>“Ягаан цээнэ” ӨЭМТ 7058-4120 |

**Төрийн үйлчилгээ /Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагууд/**

| | | |
|---|---|---|
| 1 | Байгаль орчин, аялал жуулчлалын газар | 9908-0803 |
| 2 | Биеийн тамир, спортын газар | 7058-5855 |
| 3 | Боловсрол, соёл урлагийн газар | 7058-3674 |
| 4 | Гаалийн алба | 7058-4672 |
| 5 | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | 7058-2501, 7058-5611 |
| 6 | Гэр бүл, хүүхэд, , залуучуудын хөгжлийн газар | 7058-4455, 7058-4150 |
| 7 | Зүүн бүсийн төв, Дорнод аймгийн Онцгой байдлын газар | 7058-2370, 7058-4142 |
| ,8 | Мал эмнэлэгийн газар | 7058-2270, 7058-4470 |
| 9 | Нийгмийн даатгалын хэлтэс | 7058-4102 |
| 10 | Орон нутгийн өмчийн газар | 7058-4058, 7058-4114 |
| 11 | Санхүүгийн хяналт, аудитын алба | 7058-3168 |
| 12 | Стандарт, хэмжил зүйн хэлтэс | 7058-4757 |
| 13 | Статистикийн хэлтэс | 7058-2879, 7058-4240 |
| 14 | Татварын хэлтэс | 7058-3037, 7058-3038, 7058-3288 |
| 15 | Улсын бүртгэлийн хэлтэс | 7058-4340, 7058-4341 |
| 16 | Ус, цаг уур, орчны шинжилгээний алба | 7058-3087, 7058-3178 |
| 17 | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар | 7058-4303, 7058-3031, 7058-4306 |
| 18 | Хүнс хөдөө аж ахуйн газар | 7058-5808 |
| 19 | Цагдаагийн газар<br>Замын цагдаагийн тасаг | 7019-4401, 7019-4402, 7019-4403<br>7058-4662 |
| 20 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба | 7058-4191 |
| 21 | Шүүхийн шинжилгээний алба | 7058-4090 |
| 22 | Эрүүл мэндийн газар | 7058-4830, 7058-4399, 7058-4388 |

*Иргэдийн төсвийн эмхэтгэлийг бэлтгэсэн:*

Иргэдийн төсөв боловсруулсан багийн ахлагч
О.Эрдэнэтуяа
Багийн гишүүд
С.Солонго
Д.Бүжин
Н.Оюунханд
Б.Оюун-Эрдэнэ
Б.Батмөнх

